

Ишлэлийн тайлбар:

§101 – Иргэний нисэхийн загвар хууль

ИНХ – Иргэний нисэхийн хууль 1999

ШШ Загвар – Шинжлэн шалгах ажиллагааны загвар хууль

БББ 2020 – Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын баримт бичиг

ИНД 1 – Иргэний нисэхийн нэр томъёоны дүрэм

LEG, ORG, ANS, AIG, - ОУИНБ-ын аудитын асуултууд

Гарчиг

1. БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3
1 дүгээр зүйл. Хуулийн зорилго	3
2 дугаар зүйл. Иргэний нисэхийн тухай хууль тогтоомж	3
3 дугаар зүйл. Иргэний нисэхийн үйл ажиллагааны үндсэн зарчим.....	3
4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ.....	3
5 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт.....	4
2. БҮЛЭГ. ИРГЭНИЙ НИСЭХИЙГ ТӨРӨӨС ЗОХИЦУУЛАХ	7
6 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх	7
7 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх	7
8 дугаар зүйл. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх.....	8
9 дүгээр зүйл. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг	9
10 дугаар зүйл. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын удирдлага, түүний бүрэн эрх.....	10
11 дүгээр зүйл. Эрх шилжүүлэх.....	11
3. БҮЛЭГ. ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ	12
12 дугаар зүйл. Иргэний нисэхийн дүрмийн бүтэц.....	12
13 дугаар зүйл. Иргэний нисэхийн дүрмээр зохицуулах үйл ажиллагаа.....	12
14 дүгээр зүйл. Дүрмийн шаардлагаас чөлөөлөх	13
4. БҮЛЭГ. ИРГЭНИЙ НИСЭХИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТ	14
15 дугаар зүйл. Иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын үйл ажиллагаа.....	14
16 дугаар зүйл. Иргэний нисэхийн хяналтын байцаагч, түүний бүрэн эрх.....	14
17 дугаар зүйл. Агаарын хөлгийн үндэсний харъяалал	15
18 дугаар зүйл. Агаарын хөлгийн эзэмшил	16
19 дүгээр зүйл. Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар.....	16
20 дугаар зүйл. Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ	16
21 дүгээр зүйл. Нисэхийн ажилтны үнэмлэх, гэрчилгээ	17
22 дугаар зүйл. Техник үйлчилгээний болон сургалтын байгууллагын хяналт зохицуулалт	17
23 дугаар зүйл. Иргэний нисэхийн үйлчилгээнд тавих хяналт зохицуулалт	18
24 дүгээр зүйл. Гадаадын нисэхийн баримт бичиг	18
25 дугаар зүйл. Иргэний нисэхэд гадаад хэл хэрэглэх.....	18
5. БҮЛЭГ. НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	19
26 дугаар зүйл. Нислэгийн үйл ажиллагааны төрөл.....	19
27 дугаар зүйл. Арилжааны тээврийн үйл ажиллагаа	19
28 дугаар зүйл. Нисэх клуб болон хувийн нисэхийн үйл ажиллагаа	19
29 дүгээр зүйл. Арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэгчийн эрх үүрэг	20

30	дугаар зүйл. Хөлгийн даргын бүрэн эрх	20
31	дүгээр зүйл. Нислэгийн үйл ажиллагаанд хориглох зүйлс	21
6.	БҮЛЭГ. АГААРЫН ХӨЛГИЙН ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭ БОЛОН НИСЭХИЙН СУРГАЛТ	22
32	дугаар зүйл. Агаарын хөлгийн техник үйлчилгээний ерөнхий шаардлага	22
33	дугаар зүйл. Нисэхийн ажилтны сургалтын шаардлага	22
7.	БҮЛЭГ. АГААРЫН ТЭЭВРИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЗОХИЦУУЛАЛТ	22
34	дүгээр зүйл. Агаарын тээврийн эдийн засгийн зөвшөөрөл	22
35	дугаар зүйл. Агаарын тээвэрлэгчийн хариуцлага	23
36	дугаар зүйл. Агаарын тээвэрлэгчийн өмчлөлд тавих хязгаарлалт	24
37	дугаар зүйл. Агаарын тээвэр дэх өрсөлдөөн	24
38	дугаар зүйл. Гадаадын агаарын тээвэрлэгчид зөвшөөрөл олгох	24
8.	БҮЛЭГ. ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	25
39	дүгээр зүйл. Иргэний нисэхийн үйлчилгээний байгууллага	25
40	дүгээр зүйл. Агаарын навигацийн үйлчилгээ	25
41	дүгээр зүйл. Агаарын зайн зохицуулалт	26
42	дугаар зүйл. Зөрчил гаргасан агаарын хөлөг	26
43	дугаар зүйл. Аюул тулгарсан агаарын хөлөгт тусламж үзүүлэх	27
44	дүгээр зүйл. Аэродромын үйл ажиллагаа	27
45	дугаар зүйл. Аэродромын өмчлөл	27
46	дугаар зүйл. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ	28
47	дугаар зүйл. Аюулгүйн үзлэг	28
48	дугаар зүйл. Аэродром, агаарын навигацийн байгууламжийн хамгаалалт	28
9.	БҮЛЭГ. АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ	28
49	дүгээр зүйл. Шинжлэн шалгах байгууллага	28
50	дугаар зүйл. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах	30
51	дүгээр зүйл. Шинжлэн шалгах байгууллагын даргын бүрэн эрх	30
52	дугаар зүйл. Шинжлэн-шалгагчийн бүрэн эрх	31
53	дугаар зүйл. Хариуцсан шинжлэн-шалгагчийн бүрэн эрх	31
54	дүгээр зүйл. Шинжлэн шалгах ажиллагааны тайлан	32
55	дугаар зүйл. Аюулгүй байдлын зөвлөмж	32
56	дугаар зүйл. Шинжлэн шалгах ажиллагааг сэргээх	33
10.	БҮЛЭГ. БУСАД	33
57	дугаар зүйл. Иргэний нисэхийн үйлчилгээний хураамж	33
58	дугаар зүйл. Үнэмлэх гэрчилгээтэй холбоотой гомдол гаргах	33
59	дүгээр зүйл. Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага	34

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

1. БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилго

1.1. Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, Монгол улсын агаарын зайд агаарын хөлгөөр нислэг үйлдэх, нислэгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. [ИНХ 1.1](#), [LEG 1.001](#)

2 дугаар зүйл. Иргэний нисэхийн тухай хууль тогтоомж

2.1. Иргэний нисэхийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Монгол Улсын нэгдэн орсон иргэний нисэхийн бусад конвенци, энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоос бүрдэнэ. [ИНХ 2.1](#)

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө. [ИНХ 2.2](#)

3 дугаар зүйл. Иргэний нисэхийн үйл ажиллагааны үндсэн зарчим

3.1. Иргэний нисэхийн үйл ажиллагаанд аюулгүй, үр ашигтай, хүртээмжтэй байх зарчмыг баримтална. [ЗТХЯ](#)

4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

4.1. Энэ хууль нь дараах үйл ажиллагааг зохицуулна: [ИНХ 4.1](#)

4.1.1. Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагаа;

4.1.2. Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн үйл ажиллагаа;

4.1.3. Монгол улсын нутаг дэвсгэрийн гадна нислэг үйлдэж байгаа Монгол Улсын бүртгэлтэй болон Монгол Улсын агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн үйл ажиллагаа;

4.1.4. иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын үйл ажиллагаа;

4.1.5. агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа.

4.2. Энэ хууль нь Монгол улсын агаарын зайд нислэг үйлдэж байгаа улсын агаарын хөлгийн байлдааны үүргийн нислэгээс бусад нислэгийн хөдөлгөөнийг зохицуулна. [ИНХ 4.2](#), [ИНХ 4.3](#)

4.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт онц болон дайны байдал зарласан, гамшиг бий болсон үед иргэний нисэхийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна. [ИНХ 12.1](#)

¹Монгол Улсын Үндсэн хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

5 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

- 5.1. Энэ хуульд хэрэглэсэн нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно: [ИНХ 3.1](#)
- 5.1.1. “агаарын зай” гэж Монгол улсын нутаг дэвсгэр дээгүүрх, агаарын хөлгөөр нислэг үйлдэх агаарын зайг; [§102.25](#)
- 5.1.2. “агаарын зам” гэж агаарын хөлгийн нислэгийг аюулгүйгээр гүйцэтгэхэд зориулагдсан өндөр ба өргөнөөр хязгаарлагдсан агаарын зайг; [ИНХ 3.1.1](#)
- 5.1.3. “агаарын навигацийн байгууламж” гэж гэрэлтүүлэг, радио чиглүүлэгч, цаг агаарын мэдээ дамжуулах, радио холбооны болон бодит ажиглалтын төхөөрөмж зэргээс бүрдсэн агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөн, буулт, хөөрөлтийг удирдан чиглүүлэхэд ашигладаг байгууламжийг; [§102.b.7](#)
- 5.1.4. “агаарын навигацийн үйлчилгээ” гэж нислэгийн бүх үе шатанд нислэгийн хөдөлгөөний удирдлагын, радио холбоо ажиглалтын, цаг уурын мэдээллийн, эрэн хайх болон нисэхийн мэдээллийн үйлчилгээгээр хангах цогц үйл ажиллагааг; [ICAO Doc 9734 Appendix B](#), [ИНХ 3.1.2](#)
- 5.1.5. “агаарын тээврийн эдийн засгийн зөвшөөрөл” гэж нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор Сайд энэ хуулийн дагуу агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгосон зөвшөөрлийг;
- 5.1.6. “агаарын тээвэрлэгч” гэж агаараар зорчигч, барааг хөлс, эсхүл шан урамшуулалтай тээвэрлэдэг агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийг; [§102.8](#), [ИНД-1](#), [ИНХ 3.1.23](#).
- 5.1.7. “агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ” гэж агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгосон баримт бичгийг; [§102.9](#), [ИНХ 3.1.24](#)
- 5.1.8. “агаарын хаалга” гэж улсын хилийг агаарын замаар нэвтрэх газар зүйн байрлалыг; [ИНХ 3.1.3](#)
- 5.1.9. “агаарын хөлгийн осол, зөрчил” гэж Чикагогийн конвенцийн Хавсралт 13-д заасныг; [AIG 6.341](#), [ШШ Загвар 3](#), [ИНХ 41.1](#)
- 5.1.10. “агаарын хөлөг” гэж агаар болон газрын гадаргуу хоорондын харилцан үйлчлэлээр бус, агаарын урсгалын харилцан үйлчлэлээр агаар мандалд хөөрөн нисэх чадвартай төхөөрөмжийг; /Энэ хуульд заасан агаарын хөлгийг иргэний агаарын хөлөг гэж ойлгоно./ [ИНХ 3.1.4](#), [ИНД-1](#), [§102.3](#), [ШШ Загвар 3](#)
- 5.1.11. “аэродром” гэж агаарын хөлгийн хөөрөлт, буулт болон гадаргуу дээрх хөдөлгөөнд ашиглахад зориулан газар, эсхүл усан дээр байгуулсан талбай болон нисэх буудлыг багтаасан байгууламжийг; [ИНХ 3.1.6](#), [ИНД-1](#), [§102.2](#)
- 5.1.12. “аюул тулгарсан агаарын хөлөг” гэж агаарын хөлөг, түүнд байгаа хүмүүст аюултай байж болзошгүй, эсхүл тусламж шаардлагатай нөхцөл байдалд орсон агаарын хөлгийг;
- 5.1.13. “Аюулгүй байдлын зөвлөмж” гэж агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны үр дүнд үндэслэн осол, зөрчил дахин

давтагдахаас сэргийлэх зорилгоор Шинжлэн шалгах байгууллагаас гаргасан зөвлөмжийг; [ШШ Загвар 3](#)

5.1.14. “Аюулгүй байдлын тушаал” гэж нислэгийн аюулгүй байдлын хойшлуулшгүй шаардлагаар Даргын гаргасан заавал хэрэгжүүлэх шийдвэрийг;

5.1.15. “аюултай бараа” гэж бусдын эрүүл мэнд, аюулгүй байдал, өмч хөрөнгө, эсхүл хүрээлэн буй орчинд эрсдэл учруулж болох Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Техникийн зааварчилгаанд заасан эд зүйлс, бодисыг; [ИНД-1, ИНХ 3.1.8, §102.18](#)

5.1.16. “багийн гишүүн” гэж нислэгийн үед агаарын хөлөгт үүрэг гүйцэтгэхээр томилогдсон нислэгийн ажилтныг; [§102.17, ИНД-1, ШШ Загвар 3, ИНмХ 3.1.25](#)

5.1.17. “бүртгэгч улс” гэж агаарын хөлгийг бүртгэсэн улсыг; [ШШ Загвар 3](#)

5.1.18. “иргэний нисэхийн дүрэм” гэж иргэний нисэхийн үйл ажиллагааг Чикагогийн конвенцийн Хавсралтын суурь түвшинд хангах зорилгоор боловсруулсан, иргэний нисэхийн нислэгийн аюулгүй байдлын дүрмүүдийг; [ИНХ 11.1, LEG 1.005, Chicago Convention 37, LEG 1.007](#)

5.1.19. “иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч” гэж иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн хувь хүн, хуулийн этгээдийг;

5.1.20. “иргэний нисэхийн үйл ажиллагаа” гэж агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаа болон түүнд дэмжлэг үзүүлэх иргэний нисэхийн бусад үйл ажиллагаа, үйлчилгээг;

5.1.21. “иргэний нисэхийн хяналтын байцаагч” гэж нислэгийн аюулгүй байдлын хяналт болон иргэний нисэхийн үйлчилгээний хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор Даргын томилсон ажилтныг;

5.1.22. “Монреалийн конвенци” гэж Монгол улсын нэгдэн орсон Олон улсын агаарын тээвэрт хамаарах зарим журмыг нэг мөр болгох тухай конвенцийг;

5.1.23. “нислэг үйлдэх агаарын зай” гэж агаарын хөлөг хөөрөлт, буултыг аюулгүй гүйцэтгэхэд шаардлагатай агаарын зайг багтаасан, Монгол улсын нутаг дэвсгэр дэх нислэгийн нам өндрөөс хяналттай агаарын зайн дээд хязгаар хүртэлх агаарын зайг; [§102.25](#)

5.1.24. “нислэг” гэж агаарын хөлөг нислэг үйлдэх зорилгоор зогсоолоос хөдлөхөөс эхлэн газарт бууж, хөдөлгөөнөө бүрэн зогсоох хүртэлх үйл ажиллагааг; [ИНХ 3.1.12](#)

5.1.25. “нислэгийн ажилтан” гэж хөлгийн дарга, нисгэгч, механик, багийн гишүүн, диспатчер болон агаарын хөлгийн засвар, техник үйлчилгээний ажилтныг; [§102.6](#)

5.1.26. “нислэгийн аюулгүй байдал” гэж иргэний нисэхийн үйл ажиллагааг хүний амь нас, эрүүл мэнд болон бусдын эд хөрөнгөд хохирол учруулах эрсдэлгүй гүйцэтгэх нөхцөл болон чадварыг; [ИНХ 3.1.13, AN-WP 7699](#)

- 5.1.27. “нислэгийн шинэ чиглэл” гэж сүүлийн 5 жил Монгол Улсын агаарын тээвэрлэгч хуваарьт нислэг үйлдэж байгаагүй олон улс болон орон нутгийн нислэгийн чиглэлийг;
- 5.1.28. “нислэгт тэнцэх чадвар” гэж агаарын хөлөг, түүний бүрдэл хэсэг нь нислэгийн аюулгүй байдлын шаардлагад нийцэж байгаа нөхцөл байдлыг; [ИНХ 3.1.15](#)
- 5.1.29. “нисэхийн ажилтан” гэж энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн дагуу Даргын олгосон үнэмлэх, гэрчилгээ эзэмшигчийг;
- 5.1.30. “нисэхийн аюулгүйн хамгаалалт” гэж иргэний нисэхийг хууль бус халдлагаас хамгаалах зорилготой аюулгүйн үзлэг болон харуул хамгаалалтын үйлчилгээг; [ИНХ 3.1.17](#)
- 5.1.31. “нотлох баримт” гэж шинжлэн шалгах ажиллагаатай холбоотой захидал харилцаа, санамж бичиг, заавар, журам, газрын зураг, диаграм, фото зураг, ярианы бичлэг, дүрс бичлэг, цахим файл, нислэгийн өгөгдөл, бүхээгийн яриа бичигч болон тэдгээрийн хуулбарыг багтаасан баримт материалыг; [ШШ Загвар 3](#)
- 5.1.32. “Олон улсын иргэний нисэхийн байгууллага” гэж Чикагогийн конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор 1944 онд байгуулагдсан, Нэгдсэн үндэстний байгууллагын иргэний нисэхийн чиглэлээр төрөлжсөн Канад улсын Монреаль хотод байрладаг байгууллагыг;
- 5.1.33. “Сайд” гэж иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнийг;
- 5.1.34. “улсын агаарын хөлөг” гэж цэрэг, цагдаа, хил хамгаалах, гаалийн болон төрийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын агаарын хөлгийг; [ИНХ 3.1.9](#)
- 5.1.35. “Хавсралт 13” гэж агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах үйл ажиллагааны стандарт, практик зөвлөмжийг агуулсан Чикагогийн конвенцийн Хавсралтыг; [ШШ Загвар 3](#)
- 5.1.36. “хариуцсан шинжлэн-шалгагч” гэж Шинжлэн шалгах байгууллагын өмнөөс, эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр шинжлэн шалгах ажиллагааг удирдан, гүйцэтгэхээр томилогдсон шинжлэн-шалгагчийг; [ШШ Загвар 3](#)
- 5.1.37. “хөлгийн дарга” гэж тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хариуцсан, агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн томилсон нисгэгчийг; [ИНД-1](#), [ИНХ 3.1.5](#)
- 5.1.38. “Хэлэлцэн тохирогч улс” гэж Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцид нэгдэн орсон улсыг;
- 5.1.39. “Чикагогийн конвенци” гэж Монгол Улс 1989 оны 9 сарын 7-ны өдөр нэгдэн орсон Олон улсын иргэний нисэхийн тухай конвенци, түүний Хавсралтуудыг; [§102.12](#), [ИНХ 3.1.22](#)
- 5.1.40. “Шинжлэн шалгах байгууллага” гэж агаарын хөлгийн осол, зөрчлийг Чикагогийн конвенцийн Хавсралт 13-ын дагуу шинжлэн шалгах эрх бүхий байгууллагыг;

5.1.41. “шинжлэн шалгах” гэж агаарын хөлгийн осол давтан гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, гарсан ослын шалтгааныг тогтоох, Аюулгүй байдлын зөвлөмж гаргах үйл ажиллагааг; [ИНХ 3.1.21](#), [ШШ Загвар 3](#)

5.2. Иргэний нисэхийн үйл ажиллагаанд хэрэглэдэг бусад нэр томъёог иргэний нисэхийн дүрэмд зааснаар ойлгоно.

2. БҮЛЭГ. ИРГЭНИЙ НИСЭХИЙГ ТӨРӨӨС ЗОХИЦУУЛАХ

6 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

6.1. Улсын Их Хурал иргэний нисэхийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: [ИНХ 5.1](#)

6.1.1. иргэний нисэхийн тухай хууль тогтоомжийг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих; [ИНХ 5.1.2](#)

6.1.2. иргэний нисэхийн олон улсын гэрээ, конвенцид Монгол Улс нэгдэн орох, гарах асуудлыг шийдвэрлэх; [ИНХ 5.1.3](#)

6.1.3. хуульд заасан бусад бүрэн эрх. [ИНХ 5.1.4](#)

7 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

7.1. Засгийн газар иргэний нисэхийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: [ИНХ 6.1](#)

7.1.1. иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох; [ИНХ 5.1.1](#)

7.1.2. иргэний нисэхийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; [ИНХ 6.1.1](#)

7.1.3. Засгийн газар хоорондын агаарын харилцааны хэлэлцээр байгуулах, нэмэлт, өөрчлөлт оруулах; [ЗТХЯ](#)

7.1.4. иргэний нисэхийн салбарт хэрэгжүүлэх Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үндэсний хөтөлбөрийг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих; [БББ 2020, 4.1](#), [ИНХ 6.1.4](#), [ИНХ 39.1](#)

7.1.5. иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Дарга бөгөөд Улсын ерөнхий байцаагчийг нислэгийн ажилтнаар ажилласан дадлага туршлагыг нь шалгуур болгон 5 жилийн хугацаагаар томилох ба 1 удаа улируулан томилж болно; [LEG.1.013, §201.d](#), [ИНХ 6.1.2, §204.a, b](#).

7.1.6. орон нутгийн агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний шаардлагатай нөхөн олговрын асуудлыг шийдвэрлэх; [2020-ийн 9.2, 9.5](#)

7.1.7. Шинжлэн шалгах байгууллагын дарга бөгөөд Ерөнхий шинжлэн шалгагчийг нислэгийн ажилтнаар ажилласан дадлага туршлагыг нь шалгуур болгон 5 жилийн хугацаагаар томилох ба 1 удаа улируулан томилж болно;

[ШШ Загвар 1, 7, 8, 16, 17.а, 18.а; AIG. 6.004, 6.005, LEG.1.007, ИНХ 7.1.12, ЗТХЯ 28-Sep-2018](#)

7.1.8. Шинжлэн шалгах байгууллагын зохион байгуулалтын бүтэц болон агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны дүрмийг батлах; [ШШ Загвар 1, 7, 8, 16, 17.а, 18.а; AIG. 6.004, 6.005, LEG.1.007, ИНХ 7.1.12](#)

7.1.9. агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааг Хэлэлцэн тохирогч улсын шинжлэн шалгах эрх бүхий байгууллагад бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх; [ШШ Загвар 18 \(с\); AIG.6.115](#)

7.1.10. иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн олон улсын аэродром байгуулах асуудлыг шийдвэрлэх; [2020 БББ, 6.1](#)

7.1.11. хуульд заасан бусад бүрэн эрх.

8 дугаар зүйл. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

8.1. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: [ИНХ 7.1](#)

8.1.1. Олон улсын иргэний нисэхийн байгууллагын зөвлөмжийг үндэслэн иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зохион байгуулалтын бүтцийг батлах; [ИНХ 7.1.7, §201\(a\), БББ 2020, 1.2.3](#)

8.1.2. иргэний нисэхийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах, иргэний нисэхийн салбарын хөгжлийг дэмжих зорилгоор агаарын навигацийн үйлчилгээний орлогын 50-иас доошгүй хувийг зарцуулах;

8.1.3. энэ хуулийн 9.3-т заасан санхүүжилтийн төсвийг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, батлуулах;

8.1.4. иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих; [§201.с](#)

8.1.5. иргэний нисэхийн салбарын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх; [ИНХ 7.1.1](#)

8.1.6. агаарын тээврийн эдийн засгийн зөвшөөрөл олгох, олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчийг томилох, нислэгийн шугам хуваарилах, агаарын хөлөг түрээслэх болон хариуцлагын даатгалын бодлогыг хэрэгжүүлэх; [ИНХ 7.1.11, БББ 2020, 1.2.10, §901](#)

8.1.7. Монгол Улсын Засгийн газрын бодлогоор нээсэн олон улс, орон нутгийн хуваарьт нислэгийн шинэ чиглэлд нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчид **36 хүртэлх** сарын хугацаанд иргэний нисэхийн үйлчилгээний хөнгөлөлт үзүүлэх;

8.1.8. иргэний нисэхийн талаарх Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд иргэний нисэхийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах; [ИНХ 7.1.4](#)

8.1.9. иргэний нисэхийн дүрэм батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох; [LEG.1.007, ИНХ 7.1.8](#)

8.1.10. Монгол Улсын агаарын зайд иргэний нисэхийн зориулалтаар ашиглах агаарын зам, агаарын хаалгыг тогтоох, олон улсын нислэгийн чиглэлийг нээх, хаах; [ИНХ 7.1.3](#)

8.1.11. орон нутгийн алслагдсан бүс нутагт нийгмийн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг хүргэх агаарын тээврийн хуваарьт нислэгийн үйлчилгээнд үзүүлэх хөнгөлөлтийг бодлогоор дэмжих; [ЗТХЯ, БББ 2020 9.2.](#)

8.1.12. хуульд заасан бусад бүрэн эрх.

8.2. Сайд, энэ хуулийн [8.1.5, 8.1.8](#)-д заасан бүрэн эрхээ иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Даргад (цаашид “Дарга” гэх) бичгээр, тодорхой хугацаатай шилжүүлж болох бөгөөд шилжүүлсэн эрхийн хязгаарлалтыг заана. [§201\(а\), \(с\), ИНХ 7.2](#)

8.3. Сайд бүрэн эрхээ шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй. [ЗТХЯ](#)

9 дүгээр зүйл. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

9.1. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь иргэний нисэхийн хяналт, зохицуулалтыг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын агентлаг мөн. [§201.d, §203.a,b,c, §406, ИНХ 8.1, ИНХ 8.2, LEG 1.013](#)

9.2. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.2.1. Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт, зөвлөмжийг суурь түвшинд хэрэгжүүлэх, зөрүүг Олон улсын иргэний нисэхийн байгууллагад мэдээлэх;

9.2.2. өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагатай техникийн болон хамтын ажиллагааны зохицуулалт хийх; [§419.a](#)

9.2.3. төрийн эрх бүхий байгууллагаар дамжуулан гадаадын байгууллагуудтай харилцах, мэдээлэл солилцох; [ИНХ 8.4.4, §304, ORG.2.007, §304](#)

9.2.4. үнэмлэх, гэрчилгээ олгох, үзлэг шалгалт хийх ажлын үнэлгээг тогтоох, өөрчлөх; [ИНХ 8.4.3, §306.a, 2020 БББ 9.7.6](#)

9.2.5. Монгол улсын бүртгэлтэй, эсхүл Монгол улсын агаарын тээвэрлэгчийн ашиглаж байгаа гадаад улсын бүртгэлтэй агаарын хөлгийн осол, зөрчлийг Шинжлэн шалгах байгууллага шалгаж байгаагаас үл хамааран шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэх; [§412.b, b.2 c, III Загвар 23](#)

9.2.6. орон нутгийн аэродром байгуулах, өөрчлөх асуудлыг газар өмчлөгч болон нутгийн захиргааны байгууллагатай хамтран шийдвэрлэх; [2020 БББ, 6.1](#)

9.2.7. бусад хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх.

9.3. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын санхүүжилт нь агаарын навигацийн үйлчилгээний орлогоос бүрдэнэ.

9.4. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь иргэний нисэхийн хяналтын байцаагч болон ажилтнуудын сургалтын бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор сургалтын байгууллагатай байж болно. [§411.a](#), [ORG. 2.105](#)

10 дугаар зүйл. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын удирдлага, түүний бүрэн эрх

10.1. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Дарга нь энэ хуулиар олгогдсон бүрэн эрхээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай агаарын хөлгийн инженер, эсхүл нисгэгч мэргэжлээр 15-аас доошгүй жил ажилласан туршлагатай байна. [LEG.1.013](#), [§201.d](#), [ИНХ 6.1.2](#), [§204.a, b](#), [Doc 9734 Part A, C3](#)

10.2. Нислэгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: [ИНХ 8.4](#), [LEG 1.015](#)

10.2.1. иргэний нисэхийн дүрэм болон дүрмийн нэмэлт өөрчлөлтийг боловсруулах; [§601.a](#), [§401.b](#), [ИНХ 8.4.1](#), [LEG 1.007](#), [LEG 1.009](#)

10.2.2. иргэний нисэхийн дүрмийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай зөвлөмжийн цуврал, маягт зэрэг зохион байгуулалт, технологи болон зөвлөмжийн шинж чанартай бусад баримт бичгийг батлах, тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулах; [Захиргааны ерөнхий хууль 60.1.2](#)

10.2.3. агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ олгох; [LEG 1.015](#)

10.2.4. нисэхийн ажилтны үнэмлэх, гэрчилгээ олгох; [§602.a](#), [ИНХ 39^{1.1}](#), [LEG 1.015](#)

10.2.5. Хэлэлцэн тохирогч бусад улстай нислэгийн аюулгүй байдлын хяналтын хариуцлага хуваалцах гэрээг Чикагогийн конвенцийн Зүйл 83 bis-ийн дагуу байгуулах; [LEG.1.151](#)

10.2.6. эрх бүхий холбогдох байгууллагуудтай зөвшилцөн агаарын зайн зохион байгуулалтыг хийх; [БББ2020 5.1 §407.a](#)

10.2.7. аюулгүй байдлын зөвлөмжийг үндэслэн осол, зөрчил давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах; [ИНХ 8.4.7](#), [§412.c](#)

10.2.8. онцгой нөхцөл үүссэн үед тодорхой хугацаатай “Аюулгүй байдлын тушаал” гаргаж, нийтэд яаралтай мэдээлэх; [§402.a](#), [§402.b](#), [LEG 1.023](#)

10.2.9. энэ хуулийн 9.3-т заасан санхүүжилтийг иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын үйл ажиллагаа болон ажилтнуудын сургалт, нийгмийн баталгааг хангахад зориулан захиран зарцуулах. [ИНХ 8.4.5](#)

10.2.10. Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас зөвлөмж болгосон үндэсний аюулгүй байдалтай холбоотой хөтөлбөр батлах; [ЗТХЯ](#)

10.2.11. агаарын тээвэрлэгч, техник үйлчилгээний болон сургалтын байгууллага, нислэгийн ажилтан, агаарын хөлөг, түүний бүрдэл хэсэгт үзлэг шалгалт хийх; [§609.a](#), [§610.a](#)

10.2.12. иргэний нисэхийн үйлчилгээний байгууллага, түүний ажилтан болон тоног төхөөрөмжид үзлэг шалгалт хийх; [§609.a](#), [§610.a](#)

10.2.13. агаарын хөлөг нь нислэгт тэнцэх чадвараа алдсан болон тухайн нислэг нь зорчигчид болон бусдын амь нас, эрүүл мэнд болон эд хөрөнгөд хохирол учруулж болзошгүй бол нислэгийг зогсоох; [§416.a, b, d, e](#)

10.2.14. нислэгийн ажилтан нь мэргэшил, эрүүл мэнд болон сэтгэл зүйн хувьд нислэгт бэлэн биш байгаа нь үзлэг шалгалтаар тогтоогдсон бол тухайн ажилтныг нислэгийн үйл ажиллагаанд оролцуулахгүй байх; [§416.a, c](#)

10.2.15. энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийг зөрчсөн, нислэгийн аюулгүй байдал болон нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх бол хувь хүн, хуулийн этгээдийн үнэмлэх, гэрчилгээг түдгэлзүүлэх, хүчингүй болгох; [LEG 1.015](#), [§610.b, e](#), [AGA 8.005](#), [AGA 8.013](#)

10.2.16. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх. [ИНХ 8.4.8](#)

11 дүгээр зүйл. Эрх шилжүүлэх

11.1. Дарга энэ хуулийн [10.2.2](#), [10.2.11](#), [10.2.12](#), [10.2.13](#), [10.2.14](#), [10.2.15](#)-д заасан хяналт шалгалт хийх эрхээ иргэний нисэхийн хяналтын байцаагч, ажилтан болон зохих ёсоор мэргэшсэн хувь хүнд гэрээгээр бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн, хугацаатай шилжүүлж болох бөгөөд тухайн шилжүүлсэн эрхийн хязгаарлалтыг гэрээнд тодорхой заана. [ИНХ 8.5](#), [§305.a, b](#), [LEG. 1.107](#), [§305.b](#), [ICAO, Doc 9734, 2.4.6](#)

11.2. Дарга иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ болон нисэхийн ажилтны үнэмлэх, гэрчилгээ олгох, хүчингүй болгох эрхээ бусдад шилжүүлэхгүй. [NZ act 23A.4.b](#)

11.3. Дарга энэ хуулийн [8.2](#)-ын дагуу Сайдын шилжүүлсэн эрхийг бусдад шилжүүлэхгүй. [NZ act 22.8](#)

11.4. Дарга агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч болон техник үйлчилгээний байгууллагад өөрөө өөрийгөө зохицуулах боломж олгох эрхийг шилжүүлэхгүй. [§305.b](#)

11.5. Дарга нисэх клубын үйл ажиллагааг хялбаршуулах зорилгоор шүхэрчин, шүхрийн техникч болон хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгийн ажилтны үнэмлэх, гэрчилгээ олгох эрхээ зохих ёсоор мэргэшсэн хувь хүнд шилжүүлж болно.

11.6. Дарга энэ хуулийн [11.1](#)-д заасны дагуу эрхээ шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй. [§305](#)

3. БҮЛЭГ. ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ

12 дугаар зүйл. Иргэний нисэхийн дүрмийн бүтэц

12.1. Иргэний нисэхийн үйл ажиллагааг энэ хуульд нийцүүлэн зохицуулахад иргэний нисэхийн дүрмийг баримтална. [ИНХ 11.1](#), [LEG 1.005](#), [Chicago Convention 37](#) [LEG 1.007](#)

12.2. Иргэний нисэхийн дүрмийн зохицуулалт нь иргэний нисэхийн дүрэм, түүний тайлбарыг агуулсан зөвлөмжийн цуврал, маягт болон бүртгэлийн дэвтрээс бүрдэнэ.

13 дугаар зүйл. Иргэний нисэхийн дүрмээр зохицуулах үйл ажиллагаа

13.1. Иргэний нисэхийн дүрмээр иргэний нисэхийн үйл ажиллагааны ерөнхий журам, агаарын хөлөг, ажилтнууд, агаарын зай, нислэгийн үйл ажиллагаа, агаарын тээвэрлэгч, гэрчилгээжсэн байгууллагууд, аэродром болон агаарын навигацийн байгууллагуудын үйл ажиллагааны шаардлагыг тогтооно.

13.2. Иргэний нисэхийн дүрмээр нислэгийн аюулгүй байдалтай холбоотой дараах харилцааг зохицуулна. [ИНХ 11.2](#), [NZ act 30](#)

13.2.1. нэр томъёоны тодорхойлолт ба товчлол; [\(ИНД-1\)](#)

13.2.2. зөрчлийг мэдээлэх болон албадлага; [ИНД-12](#), [ИНД-13](#).

13.2.3. агаарын хөлөг, бүтээгдэхүүн, эд ангийн гэрчилгээжүүлэлт, агаарын хөлгийн бүртгэл, нислэгт тэнцэх чадварын удирдамж болон нэмэлт шаардлага, техник үйлчилгээ; [\(ИНД-21](#), [ИНД-47](#), [ИНД-39](#), [ИНД-26](#), [ИНД-43\)](#)

13.2.4. аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, шилжилтийн зохицуулалт; [\(ИНД-100](#), [ИНД-19\)](#)

13.2.5. нисгэгч, нисэх инженер, агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтан болон нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтны үнэмлэх, эрүүл мэндийн гэрчилгээ; [\(ИНД-61](#), [ИНД-63](#), [ИНД-66](#), [ИНД-65](#), [ИНД-67\)](#)

13.2.6. агаарын зайн ангилал болон нислэг үйлдэх агаарын зайн зохицуулалт; [\(ИНД-71](#), [ИНД-77\)](#)

13.2.7. нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрэм, хэрэглэлийн нислэгийн журам; [\(ИНД-91](#), [ИНД-95\)](#)

13.2.8. жиро-глайдер, парасэйл болон цаасан шувуу, пуужин, бөмбөлөг, дроныг багтаасан хүнгүй агаарын хөлгийн үйл ажиллагаа, хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээжүүлэлт [\(ИНД-101](#), [ИНД-102\)](#)

13.2.9. хэт хөнгөн, глайдер, ханг-глайдер болон шүхрийн үйл ажиллагаа, нисэх клубийн гэрчилгээжүүлэлт; [\(ИНД-103](#), [ИНД-104](#), [ИНД-106](#), [ИНД-105](#), [ИНД-149\)](#)

13.2.10. агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт, жижиг, дунд, том агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаа болон гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт; [\(ИНД-119](#), [ИНД-121](#), [ИНД-125](#), [ИНД-135](#), [ИНД-129\)](#)

13.2.11. нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт болон агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр; [\(ИНД-108](#), [ИНД-140\)](#)

13.2.12. нисдэг тэрэгний дүүжинт тээврийн, хөдөө аж ахуйн агаарын хөлгийн үйл ажиллагаа, чөлөөт нисэхийн үйл ажиллагааны гэрчилгээжүүлэлт; [\(ИНД-115, ИНД-133, ИНД-137\)](#)

13.2.13. агаарын хөлөг зохион бүтээх, үйлдвэрлэх болон техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт; [\(ИНД-146, ИНД-148, ИНД-145\)](#)

13.2.14. нисэхийн сургалтын болон техник үйлчилгээний сургалтын байгууллагын гэрчилгээжүүлэлт; [\(ИНД-141, ИНД-147\)](#)

13.2.15. агаараар аюултай бараа тээвэрлэх болон зохицуулалттай агаарын ачааны байгууллагын гэрчилгээжүүлэлт; [\(ИНД-92, ИНД-109\)](#)

13.2.16. аэродром байгуулах болон аэродромын үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт; [\(ИНД-157, ИНД-139\)](#)

13.2.17. нисэхийн холбоо, нислэгийн хөдөлгөөн, хэрэглэлийн нислэгийн журам зохиох, нисэхийн цаг уурын болон нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт; [\(ИНД-171, ИНД-172, ИНД-173, ИНД-174, ИНД-175\)](#)

13.2.18. иргэний нисэхийн дүрмээр зохицуулах шаардлагатай бусад үйл ажиллагаа. [Кон. 37, ICAO Doc 9734, 3.3](#)

13.3. Энэ хуулийн 13.2-т заасан үйл ажиллагааг нэг, эсхүл хэд хэдэн иргэний нисэхийн дүрмээр зохицуулж болно.

13.4. Иргэний нисэхийн дүрэм нь олон улсын иргэний нисэхийн жишиг дүрмийн ангилал, дугаарлалт, бүтэц болон хэлбэрийг хадгалсан байна.

14 дүгээр зүйл. Дүрмийн шаардлагаас чөлөөлөх

14.1. Дарга иргэний нисэхийн дүрмээр хориглоогүй бол агаарын хөлөг, нисэхийн бүтээгдэхүүн, аэродром, иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч болон нисэхийн ажилтныг иргэний нисэхийн дүрмийн шаардлагаас дараах тохиолдолд чөлөөлж болно: [§405](#)

14.1.1. хүсэлт гаргагч иргэний нисэхийн дүрмийн тухайн шаардлагыг хүлээн зөвшөөрөхүйц бусад хэлбэрээр хангасан бол; эсхүл

14.1.2. хүсэлт гаргагчийн хэрэгжүүлэхээр санал болгосон арга хэмжээ нь иргэний нисэхийн дүрмийн тухайн шаардлагыг хэрэгжүүлснээс илүү үр дүнтэй байгаа бол;

14.1.3. иргэний нисэхийн дүрмийн тухайн шаардлагаас чөлөөлснөөр нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй болох нь тогтоогдсон бол. [NZ act 37](#)

14.2. Дарга иргэний нисэхийн дүрмийн шаардлагаас чөлөөлсөн шийдвэрийг нийтэд мэдээлнэ.

4. БҮЛЭГ. ИРГЭНИЙ НИСЭХИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТ

15 дугаар зүйл. Иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын үйл ажиллагаа

15.1. Иргэний нисэхийн хяналт, зохицуулалт нь нислэгийн аюулгүй байдлын болон иргэний нисэхийн үйлчилгээний хяналт, зохицуулалтаас бүрдэнэ: [ICAO Doc 9734 3.4](#)

15.2. Нислэгийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ: [§413.c.1](#), [§413.c.2](#), [§413.c.3, Doc 9379](#); [ICAO Doc 9734 3.4](#)

15.2.1. агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын хяналт;

15.2.2. нислэгийн үйл ажиллагааны стандарт;

15.2.3. нисэхийн ажилтны үнэмлэх, гэрчилгээжүүлэлт;

15.3. Нислэгийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалт хариуцсан удирдах ажилтан нь агаарын хөлгийн болон нислэгийн үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн нислэгийн ажилтан байна.

15.4. Иргэний нисэхийн үйлчилгээний хяналт, зохицуулалтыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ: [ICAO Doc 9734 3.4](#), [БББ 2020 4.2](#), [ORG 2.009, LEG 1.010](#)

15.4.1. агаарын навигацийн үйлчилгээ;

15.4.2. аэродромын үйлчилгээ;

15.4.3. нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ.

15.5. Иргэний нисэхийн үйлчилгээний хяналт, зохицуулалт хариуцсан удирдах ажилтан нь агаарын навигацийн чиглэлээр мэргэшсэн нисэхийн ажилтан байна.

15.6. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуульд заасан иргэний нисэхийн хяналт, зохицуулалтыг тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүүгийн чадавхитай байна. [§413.b, ORG 2.009, БББ 2020 4.3, 4.4](#)

16 дугаар зүйл. Иргэний нисэхийн хяналтын байцаагч, түүний бүрэн эрх

16.1. Дарга тухайн хэрэгжүүлэх хяналтын чиглэлээр багшийн, эсхүл шалгагчийн зэрэглэл эзэмшдэг, эсхүл агаарын хөлгийн нислэгийн аюулгүй байдалтай холбоотой шийдвэр гаргах ажил үүргийг 5-аас доошгүй жил гүйцэтгэсэн дадлага туршлагатай нисэхийн ажилтныг иргэний нисэхийн хяналтын байцаагчаар томилно. [§205.a, ICAO, Doc 9734, 3.5.1.3, Doc 9734 3.4.2.1, 3.4.2.3](#)

16.2. Иргэний нисэхийн хяналтын байцаагч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: [ИНХ 9.1](#)

16.2.1. Монгол Улсад нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлөг нь нислэгт тэнцэх чадвартай бөгөөд нислэгийн үйл ажиллагаа нь энэ хууль, иргэний нисэхийн дүрэм болон Чикагогийн конвенцийн холбогдох Хавсралтын шаардлагыг хангаж байгааг бататгах үзлэг шалгалт хийх зорилгоор агаарын хөлөгт аль ч үед саадгүй нэвтрэх; [§415.a LEG. 1.101](#),

16.2.2. Монгол Улсын бүртгэлтэй, эсхүл Монгол Улсын агаарын тээвэрлэгчийн ашиглаж байгаа агаарын хөлөг нь аль улсад үйл ажиллагаа гүйцэтгэж байгаагаас үл хамааран, нислэгт тэнцэх чадвартай бөгөөд

нислэгийн үйл ажиллагаа нь энэ хууль, иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг хангаж байгааг бататгах үзлэг шалгалт хийх зорилгоор аль ч үед саадгүй нэвтрэх; [§415.b, LEG. 1.101](#)

16.2.3. энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг хангаж байгааг бататгах зорилгоор иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн дараах барилга байгууламжид аль ч үед саадгүй нэвтрэх; [§415.c, LEG. 1.101](#)

- 16.2.3.1. агаарын хөлөг;
- 16.2.3.2. агаарын тээвэрлэгчийн ажлын байр;
- 16.2.3.3. ангар;
- 16.2.3.4. техник үйлчилгээний байгууллага;
- 16.2.3.5. засвар үйлчилгээний газар;
- 16.2.3.6. агаарын хөлгийн зогсоол;
- 16.2.3.7. аэродром;
- 16.2.3.8. агаарын навигацийн үйлчилгээний байгууламж;
- 16.2.3.9. шатахуун хадгалах байгууламж;
- 16.2.3.10. ачаа тээвэрлэх байгууламж;
- 16.2.3.11. нисэхийн сургалтын байгууллагын байгууламж;

16.2.4. хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох хувь хүн, хуулийн этгээдээс шаардан гаргуулж авах; [ИНХ 9.1.2, LEG. 1.103](#)

16.2.5. Даргын шилжүүлсэн бусад эрх. [ИНХ 9.1.4](#), [LEG. 1.111](#), [§416](#), [LEG. 1.109](#), [ИНХ 9.1.3](#), [ICAO Doc 9734, 3.9](#)

16.3. Иргэний нисэхийн хяналтын байцаагч, ажилтны цалин хөлс нь салбарын ижил мэргэжлийн ажилтны дундаж цалингаас багагүй байна. [Doc 9734 \(3.4.2.1, 3.4.2.3\)](#), [БББ 2020](#)

16.4. Иргэний нисэхийн хяналтын байцаагч нь энэ хуулиар олгогдсон хяналтын үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай хөдөлмөр хамгааллын хувцас болон техник хэрэгслээр хангагдана. [ТХШмХ 11.1.4](#), [ИНХ 8.3](#)

16.5. Иргэний нисэхийн хяналтын байцаагч нь түүний эрхийн хүрээг тодорхой заасан үнэмлэхтэй байна. [AGA 8.045](#), [AIG 6.121](#), [AIR 5.035](#), [ANS 7.042](#), [OPS 4.035](#), [PEL 3.114](#)

17 дугаар зүйл. Агаарын хөлгийн үндэсний харъяалал

17.1. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь агаарын хөлгийн үндэсний харъяаллыг тодорхойлох бүртгэлийн системтэй байна. [§501.a](#)

17.2. Монгол Улсад, эсхүл гадаад улсад бүртгүүлээгүй агаарын хөлгөөр нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхийг хориглоно. [§501.b](#)

17.3. Гадаад улсын бүртгэлгүй, дараах хувь хүн, хуулийн этгээдийн эзэмшилд байгаа агаарын хөлгийг энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн дагуу Монгол Улсад бүртгэж, бүртгэлийн гэрчилгээ олгож болно: [§501.c](#) [§501.d](#) [§501.e](#)

17.3.1. Монгол Улсын иргэн; [§501.с.1](#)

17.3.2. Хуулийн дагуу Монгол Улсад байнга оршин суугч гадаадын иргэн; [§501.с.2](#)

17.3.3. тухайн агаарын хөлөг нь Монгол Улсад байрлаж, ашиглагддаг бөгөөд Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд; [§501.с.3](#)

17.3.4. Монгол Улсын төрийн өмчит хуулийн этгээд. [§501.с.4](#)

17.4. Энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийг зөрчсөн, эсхүл нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх нөхцөл үүссэн тохиолдолд Дарга агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгоно. [§501.f, ИНХ 16.3](#)

17.5. Агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ нь тухайн агаарын хөлгийн харъяаллыг гэрчлэх бөгөөд агаарын хөлгийн эзэмшилтэй холбоотой харилцаанд өмчлөлийг нотлох баримт болохгүй. [§501.g](#)

18 дугаар зүйл. Агаарын хөлгийн эзэмшил

18.1. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг, хөдөлгүүр, сэнс, хэрэгсэл болон бусад сэлбэг эд ангийн эзэмшлийг бүртгэх системийг тогтоосон байна. [§502.a](#)

18.2. Энэ хуулийн 18.1-д заасан эзэмшлийг бүртгэх системд ороогүй, Монгол улсын бүртгэлтэй агаарын хөлөг, хөдөлгүүр, сэнс, хэрэгсэл, сэлбэг эд ангийн эзэмшилд нөлөөлөх баримт бичгийг хүчингүйд тооцно. [§502.b](#)

19 дүгээр зүйл. Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар

19.1. Монгол улсын бүртгэлтэй агаарын хөлөг эзэмшигч нь тухайн агаарын хөлөгт нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ эзэмших хүсэлтийг Даргад гаргана. [§603.a](#)

19.2. Агаарын хөлгийн маягийн гэрчилгээ болон нислэгийн аюулгүй байдлын нөхцөл, шаардлагад нийцэж байгаа нь үзлэг шалгалтаар тогтоогдсон агаарын хөлөгт Дарга нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгоно. [ИНХ 39^2.1, §603.b](#)

19.3. Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээнд түүний хүчинтэй хугацаа, агаарын хөлгийн зориулалт, нислэгийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай эрх, хязгаарлалт болон бусад мэдээллийг заасан байна. [ИНХ 39^2.1, §603.c](#)

19.4. Агаарын хөлгийн эзэмшигч нь агаарын хөлгийн нэмэлт нислэгт тэнцэх чадварын гэрчилгээнд өөрчлөлт оруулахыг шаардсан сайжруулалтыг Даргын зөвшөөрөлтэй гүйцэтгэнэ. [§603.d, Кон. 31, ICAO Doc 9734, 3.7.1.1](#)

20 дугаар зүйл. Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ

20.1. Энэ хуулийн 34.1-ийн дагуу олгосон агаарын тээврийн эдийн засгийн зөвшөөрөлтэй Монгол улсын иргэн, хуулийн этгээд агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлтийг Даргад гаргана. [§604.b](#)

20.2. Агаарын тээвэрлэгчийн нислэгийн аюулгүй байдлын минимум стандартыг хэрэгжүүлж чадах Монгол Улсын Иргэнд, эсхүл Монгол Улсын иргэн 75-аас дээш хувийг эзэмшдэг, Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн

этгээдэд Дарга дараах төрлийн агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ олгож болно: [§604.а](#), [ИНХ 39^3.1, ИНД-300](#)

20.2.1. шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ;

20.2.2. ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ.

20.3. Энэ хуулийн 38.2-ын дагуу Сайдын олгосон зөвшөөрөлтэй гадаадын агаарын тээвэрлэгч энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг хангасан тохиолдолд Дарга гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ олгож болно.

20.4. Энэ хуулийн 20.2-ын дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг бусдад шилжүүлэхийг хориглоно. [ААҮАТЗмХ 5.3](#)

21 дүгээр зүйл. Нисэхийн ажилтны үнэмлэх, гэрчилгээ

21.1. Нисэхийн ажилтны үнэмлэх, гэрчилгээ эзэмших хүсэлт гаргасан этгээд нь мэргэжил, эрүүл мэндийн хувьд иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг хангасан тохиолдолд Дарга мэргэжлийн үнэмлэх, эрүүл мэндийн гэрчилгээ олгож болно. [§602.а](#), [§606.а, ИНХ 39^1.1](#)

21.2. Нисэхийн ажилтан нь эзэмшиж байгаа үнэмлэх, гэрчилгээний эрх, хязгаарлалт, энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийг дагаж мөрдөх үүрэгтэй. [§608.с](#)

21.3. Үнэмлэх гэрчилгээ нь нислэгийн аюулгүй байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай эрх, хязгаарлалтыг агуулсан байна. [§602.с](#).

21.4. Нисэхийн ажилтны үнэмлэх, гэрчилгээ нь дараах шаардлагыг хангасан байна:

21.4.1. иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүртгэж, дугаарласан байх; [§602.е.1](#)

21.4.2. тухайн үнэмлэх, гэрчилгээ олгосон байгууллагын нэр, хаягийн мэдээллийг агуулсан байх; [§602.е.2](#)

21.4.3. тухайн гүйцэтгэх ажил үүрэг болон түүний эрхийг тодорхой заасан байх. [§602.е.3, Кон. 32, ICAO Doc 9734, 3.7](#)

22 дугаар зүйл. Техник үйлчилгээний болон сургалтын байгууллагын хяналт зохицуулалт

22.1. Дарга нь агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн техник үйлчилгээ, их засвар, өөрчлөлтийг хийх байгууллагын ажилтны ур чадвар, тоног төхөөрөмж, байгууламж, засвар үйлчилгээний аргачлал, ашиглаж байгаа материалд үзлэг шалгалт хийнэ. [§605.а.2](#)

22.2. Энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн шаардлага хангасан агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагад Дарга гэрчилгээ олгож болно. [§605.б, Doc 9734, 3.8](#)

22.3. Дарга нь нисэхийн ажилтан бэлтгэх сургалтын байгууллагын хөтөлбөр, багшлах бүрэлдэхүүний ур чадвар, агаарын хөлөг, дадлагажуур болон сургалтын тоног төхөөрөмжид үзлэг шалгалт хийнэ. [§605.а, §605.а.1](#)

22.4. Энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн шаардлага хангасан нисэхийн сургалтын байгууллагад Дарга гэрчилгээ олгож болно. [§605.б, Doc 9734, 3.8](#)

23 дугаар зүйл. Иргэний нисэхийн үйлчилгээнд тавих хяналт зохицуулалт

23.1. Иргэний нисэхийн үйлчилгээ гэж нислэгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг агаарын навигаци, аэродром болон нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг ойлгоно.

23.2. Дарга иргэний нисэхийн үйлчилгээний байгууллага, түүний байгууламж, тоног төхөөрөмж болон ажилтнууд нь энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн шаардлага хангасан тохиолдолд гэрчилгээ олгож болно. [§609.a](#), [§610.a](#)

23.3. Иргэний нисэхийн үйлчилгээний байгууллага нь ашиглаж байгаа тоног төхөөрөмжийн үзлэг, засвар үйлчилгээг үйл ажиллагааны зааврын дагуу хийж, үйл ажиллагааг энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн дагуу гүйцэтгэж байгааг бататгах үүрэгтэй. [§608.a](#)

23.4. Иргэний нисэхийн үйлчилгээний болон хамтран ажилладаг бусад байгууллагын ажилтнууд нь эзэмшиж байгаа үнэмлэх, гэрчилгээний эрх, хязгаарлалт, холбогдох хууль болон иргэний нисэхийн дүрмийг дагаж мөрдөх үүрэгтэй. [§608.d](#), [§404](#)

24 дүгээр зүйл. Гадаадын нисэхийн баримт бичиг

24.1. Дарга, гадаадын иргэний нисэхийн эрх бүхий байгууллагаас олгосон үнэмлэх, гэрчилгээг нарийвчлан судалсны үндсэн дээр, дараах тохиолдолд хүлээн зөвшөөрч болно: [§414.a](#), [ИНХ 33.1](#)

24.1.1. тухайн улс нь Хэлэлцэн тохирогч улс бөгөөд нислэгийн ажилтны үнэмлэх, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээг Чикагогийн Конвенцийн шаардлагын дагуу олгодог ба түүний хүчинтэй байдалд тогтмол хяналт тавьдаг бол; [§414.b](#)

24.1.2. гадаадын иргэний нисэхийн эрх бүхий байгууллага нь агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг Чикагогийн Конвенцийн шаардлагын дагуу олгодог бөгөөд тогтмол хяналт тавьдаг бол. [§414.c](#)

24.2. Дарга гадаадын нислэгийн ажилтны үнэмлэх, зэрэглэл болон гэрчилгээнд эрх, хязгаарлалтыг тогтоож болно. [§602.d](#)

24.3. Хэлэлцэн тохирогч улсаас олгосон үнэмлэх, эрүүл мэндийн гэрчилгээг тухайн ажилтныг мэргэжил, эрүүл мэндийн хувьд ажил үүрэг гүйцэтгэх чадвартай болохыг нотлох баримтаар тооцож болно. [§602.b](#)

25 дугаар зүйл. Иргэний нисэхэд гадаад хэл хэрэглэх

25.1. Иргэний нисэхийн үйл ажиллагаанд ашиглах техникийн стандарт, технологийн баримт бичиг, заавар болон иргэний нисэхийн дүрмийн зөвлөмжийн цуврал, маягт, бүртгэлийн дэвтрийг англи, орос хэл дээр боловсруулан, ашиглаж болно. [ИНХ 14.1](#).

25.2. Монгол Улсын агаарын зайд нислэгийн хөдөлгөөнийг монгол болон англи хэл дээр удирдана. [ИНХ 14.2](#)

5. БҮЛЭГ. НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

26 дугаар зүйл. Нислэгийн үйл ажиллагааны төрөл

26.1. Нислэгийн үйл ажиллагаа нь арилжааны тээврийн үйл ажиллагаа болон нисэх клуб, хувийн нисэхийн үйл ажиллагаанаас бүрдэнэ.

26.2. Тусгай зориулалтын нисэх, чөлөөт нисэх, нисэх клуб болон хувийн нисэхийн үйл ажиллагааг ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа гэж ойлгоно.

27 дугаар зүйл. Арилжааны тээврийн үйл ажиллагаа

27.1. Арилжааны тээврийн үйл ажиллагаа нь агаарын тээврийн, тусгай зориулалтын нисэхийн болон чөлөөт нисэхийн хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагаанаас бүрдэнэ.

27.2. Агаарын тээврийн үйл ажиллагаа гэж зорчигч, барааг хөлс, эсхүл шан урамшуулалтай тээвэрлэх шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн арилжааны нислэгийн дараах үйл ажиллагааг ойлгоно. [ИНД-1](#)

27.2.1. 30-аас дээш зорчигчийн суудлын багтаамжтай том нисэх онгоцоор гүйцэтгэх үйл ажиллагаа;

27.2.2. 10-аас 30 хүртэл зорчигчийн суудлын багтаамжтай дунд нисэх онгоцоор гүйцэтгэх үйл ажиллагаа;

27.2.3. нисдэг тэргээр, эсхүл 10-аас доош зорчигчийн суудлын багтаамжтай нисэх онгоцоор гүйцэтгэх үйл ажиллагаа;

27.2.4. Засгийн газар хоорондын агаарын харилцааны хэлэлцээрийн дагуу томилогдсон гадаадын агаарын тээвэрлэгчийн хуваарьт нислэгийн үйл ажиллагаа.

27.3. Тусгай зориулалтын нисэхийн үйл ажиллагаанд дараах үйл ажиллагаа багтана:

27.3.1. нисдэг тэргээр, эсхүл 10-аас доош зорчигчийн суудлын багтаамжтай нисэх онгоцоор бөглүү аэродромоос, эсхүл бөглүү аэродром руу зорчигч, барааг хөлс, эсхүл шан урамшуулалтай тээвэрлэх ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа; [ИНД-1](#)

27.3.2. нисдэг тэрэгний дүүжинт тээвэр, хөдөө аж ахуйн агаарын хөлгийн үйл ажиллагааг багтаасан агаараас гүйцэтгэх үйл ажиллагаа.

27.4. Чөлөөт нисэхийн үйл ажиллагаанд шүхэр, агаарын бөмбөлөг, хэт хөнгөн, хөнгөн агаарын хөлгийн хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагаа багтана.

28 дугаар зүйл. Нисэх клуб болон хувийн нисэхийн үйл ажиллагаа

28.1. Нисэх клуб болон өөрийн эзэмшлийн агаарын хөлгөөр гүйцэтгэж байгаа хувийн нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч нь дараах үүрэгтэй:

28.1.1. нислэгт тэнцэх чадварын шаардлага хангасан агаарын хөлөгтэй байх;

28.1.2. хүчинтэй үнэмлэх, гэрчилгээ эзэмшдэг нислэгийн ажилтантай байх;

28.1.3. үйл ажиллагаандаа тохирсон заавартай байх;

28.2. Нисэх клуб болон хувийн нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг бүрэн хариуцна.

28.3. Нисэх клуб болон хувийн нисэхийн үйл ажиллагаа нь ашгийн төлөө бус байх ба зөвхөн үйл ажиллагааны зардлаа нөхөх зорилгоор төлбөр авч болно. [ИНД-1 зардал хуваах-cost share](#)

28.4. Нисэх клуб болон хувийн нисэхийн үйл ажиллагаанд энэ хууль болон иргэний нисэхийн дүрмээс давсан хориг, хязгаарлалт тогтоохыг хориглоно. [2020 БББ 1.2.9, ЗГ 2016-2020](#)

29 дүгээр зүйл. Арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэгчийн эрх үүрэг

29.1. Арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэгч нь дараах үүрэгтэй:

29.1.1. нислэгийн үйл ажиллагааг гэрчилгээний эрх, хязгаарлалтын хүрээнд гүйцэтгэх; [§608.b, ИНХ 34.1](#)

29.1.2. иргэний нисэхийн дүрмийн шаардлага хангасан бүтэц, удирдах ажилтантай байх;

29.1.3. үйл ажиллагаандаа тохирсон агаарын хөлөг болон хангалттай тооны нислэгийн ажилтантай байх;

29.1.4. ашиглаж байгаа агаарын хөлөг болон түүний эд ангийн үзлэг, засвар үйлчилгээг гэрчилгээний эрх, хязгаарлалтын хүрээнд гүйцэтгэх; [§608.b, ИНХ 34.1](#)

29.1.5. осол, зөрчил давтан гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор тухайн осол, зөрчлийн дотоод шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэх; [§412](#)

29.1.6. аюултай барааг иргэний нисэхийн дүрэм болон Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Техникийн зааварчилгааны дагуу тээвэрлэх. [§417](#)

29.2. Тогтмол агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэх шугамын агаарын тээвэрлэгч нь хоёроос доошгүй ижил маягийн агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэх үүрэгтэй.

30 дугаар зүйл. Хөлгийн даргын бүрэн эрх

30.1. Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь нислэгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор тухайн нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай үнэмлэх, гэрчилгээтэй нисгэгчийг агаарын хөлгийн даргаар томилно.

30.2. Агаарын хөлгийн дарга нислэгийн үед дараах онцгой нөхцөл үүссэн тохиолдолд үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор энэ хууль болон иргэний нисэхийн дүрэмд зааснаас өөр шийдвэр гаргах эрхтэй: [NZ act 13.1.2](#)

30.2.1. хүний амь нас, эд хөрөнгөд аюул учирсан; [ИНХ 18.2.1](#)

30.2.2. тухайн шийдвэрийг зөвхөн онцгой нөхцөлийг зохицуулах зорилготой;

30.2.3. тухайн онцгой нөхцөлийг өөр арга хэлбэрээр шийдвэрлэх боломжгүй бол;

30.2.4. иргэний нисэхийн дүрмийг мөрдөх нь аюултай нөхцөл байдлыг нэмэгдүүлэх бол;

30.3. Агаарын хөлөг, багийн бусад гишүүд болон зорчигчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор тухайн нислэгийн үйл ажиллагаатай холбоотой эцсийн шийдвэр гаргах эрхтэй. [ИНХ 18.2.2, 18.2.3](#)

30.4. Энэ хуулийн 30.2-т заасан онцгой нөхцөл үүссэн үед хүний амь нас, эд хөрөнгийг хамгаалах зорилгоор эмнэлгийн болон бусад яаралтай тусламж хүргэх нислэгийг энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийг зөрчин гүйцэтгэж болно. [NZ act 13A.3](#)

30.5. Энэ хуулийн 30.4-т заасан нислэгийг бүртгэлгүй, эсхүл нислэгт тэнцэх чадварын шаардлага хангаагүй агаарын хөлгөөр, эсхүл тухайн агаарын хөлгөөр нисэх эрхгүй этгээд гүйцэтгэхийг зөвшөөрөхгүй. [NZ act 13A.5](#)

30.6. Хөлгийн дарга нь энэ зүйлд заасан онцгой нөхцөлийн үед иргэний нисэхийн дүрэмд зааснаас өөр үйлдэл хийсэн бол энэ тухай агаарын навигацийн үйлчилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй. [ИНХ 18.2.5, NZ act 13.6.a](#)

30.7. Хөлгийн дарга нь онцгой нөхцөлтэй холбоотойгоор иргэний нисэхийн дүрмийг зөрчсөн тохиолдолд тайланг Даргад бичгээр хүргүүлэх үүрэгтэй. [NZ act 13.6.b](#)

30.8. Хөлгийн дарга нь нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болох үйлдэл гаргасан зорчигчийн үйлдлийг таслан зогсооход чиглэсэн арга хэмжээ авах үүрэгтэй. [ИНХ 18.2.4, Tokyo con.](#)

31 дүгээр зүйл. Нислэгийн үйл ажиллагаанд хориглох зүйлс

31.1. Нислэгийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно: [§611.a, LEG 1.051, LEG. 1.111](#)

31.1.1. нислэгт тэнцэх чадварын шаардлага хангаагүй агаарын хөлөг, түүний эд ангийг нислэгийн үйл ажиллагаанд ашиглах; [§609.b](#)

31.1.2. нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ нь хүчингүй болсон, эсхүл гэрчилгээний эрх, хязгаарлалтыг зөрчин агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэх; [§611.a.1](#)

31.1.3. агаарын тээвэрлэгчийн гэрчилгээгүй, эсхүл гэрчилгээний эрх, хязгаарлалт, энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийг зөрчин нислэгийн үйл ажиллагаа эрхлэх; [§611.a.4, 5](#)

31.1.4. иргэний нисэхийн дүрэм, үнэмлэх гэрчилгээний эрх, хязгаарлалтыг зөрчин нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа агаарын хөлөг, түүний бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийх; [§611.a.2](#)

31.1.5. агаарын хөлөгтэй холбоотой ажил, үйлчилгээнд нислэгийн ажилтны үнэмлэх, гэрчилгээгүй этгээдийг ажиллуулах, тухайн этгээдэд гэрчилгээгээр олгосон эрхээс хэтэрсэн ажил үүрэг гүйцэтгүүлэх; [§611.a.3, LEG. 1.111](#)

31.1.6. нислэгийн үед хөлгийн даргын зөвшөөрөлгүйгээр агаарын хөлгийн нисэх багийн бүхээгт нэвтрэх;

31.1.7. зорчигч тээврийн агаарын хөлгөөр аюултай барааг иргэний нисэхийн дүрмийг зөрчин тээвэрлэх. [§608.e, ИНХ 35.1](#)

6. БҮЛЭГ. АГААРЫН ХӨЛГИЙН ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭ БОЛОН НИСЭХИЙН СУРГАЛТ

32 дугаар зүйл. Агаарын хөлгийн техник үйлчилгээний ерөнхий шаардлага

32.1. Монгол Улсын бүртгэлтэй, эсхүл Даргад бүртгэгч улсаас гэрээгээр эрх нь шилжигдсэн агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн техник үйлчилгээг энэ хуулийн 22.2-ын дагуу гэрчилгээжсэн, эсхүл Даргын хүлээн зөвшөөрсөн, Хэлэлцэн тохирогч улсын агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллага гүйцэтгэнэ.

32.2. Техник үйлчилгээний байгууллага нь агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн техник үйлчилгээ болон засварыг гэрчилгээний эрх, хязгаарлалтын хүрээнд, батлагдсан техникийн болон үйл ажиллагааны заавар, журмын дагуу гүйцэтгэх үүрэгтэй. §608.а, §611.а.6, ИНХ 34.1

32.3. Техник үйлчилгээний байгууллага нь тухайн гэрчилгээнд заасан техник үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай бүтэц, инженер, техникийн ажилтан болон барилга байгууламж, тоног төхөөрөмжтэй байна.

33 дугаар зүйл. Нисэхийн ажилтны сургалтын шаардлага

33.1. Нисэхийн ажилтны үнэмлэх, гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь үйлдвэрлэгчийн, эсхүл энэ хуулийн 22.4-ийн дагуу гэрчилгээжсэн нисэхийн сургалтын байгууллагад, эсхүл Даргын хүлээн зөвшөөрсөн, Хэлэлцэн тохирогч улсын нисэхийн сургалтын байгууллагад сурч мэргэшсэн байна.

33.2. Нисэхийн сургалтын байгууллага нь сургалтын үйл ажиллагааг тухайн гэрчилгээний эрх, хязгаарлалтын хүрээнд, батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулах үүрэгтэй. §611.а.6

33.3. Нисэхийн сургалтын байгууллага нь тухайн гэрчилгээнд заасан сургалтыг зохион байгуулахад шаардлагатай бүтэц, мэргэжлийн багшлах бүрэлдэхүүн, сургалтын хөтөлбөр, агаарын хөлөг, дадлагажуур болон сургалтын тоног төхөөрөмжтэй байна.

7. БҮЛЭГ. АГААРЫН ТЭЭВРИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЗОХИЦУУЛАЛТ

34 дүгээр зүйл. Агаарын тээврийн эдийн засгийн зөвшөөрөл

34.1. Сайд нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан даатгалын бодлогыг хэрэгжүүлэх чадвартай, агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн Монгол Улсын иргэнд агаарын тээврийн эдийн засгийн зөвшөөрөл олгож болно. §901.с §901.н, ИНХ 7.1.11

34.2. Сайд энэ хуулийн 34.1-д заасан зөвшөөрөлд нисэн хүрэх цэг, завсрын цэг, нислэгийн чиглэлийг заах ба шаардлагатай нөхцөл, хязгаарлалтыг тогтоож болно. §901.е.1, §901.е.2

34.3. Агаарын тээврийн эдийн засгийн зөвшөөрөлтэй этгээд нь энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг байнга мөрдөх үүрэгтэй. §901.и, ИНХ39^4.1

34.4. Агаарын тээвэрлэгч нь энэ хууль болон иргэний нисэхийн дүрэм, агаарын тээврийн эдийн засгийн зөвшөөрөлд заасан нөхцөл, хязгаарлалтыг зөрчсөн

тохиолдолд Сайд тухайн зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох эрхтэй. [§901.f.1, §901.i](#)

34.5. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд, энэ хуулийн 34.1-д заасны дагуу олгосон зөвшөөрлийг түдгэлзүүлэх, өөрчлөх, эсхүл хүчингүй болгох хүсэлтийг Сайдад гаргаж болно. [§901.f.2](#)

34.6. Сайд нийтийн ашиг сонирхолд нийцнэ гэж үзсэнээс бусад тохиолдолд агаарын тээврийн эдийн засгийн зөвшөөрлийг бусдад шилжүүлэхгүй. [§901.g](#)

35 дугаар зүйл. Агаарын тээвэрлэгчийн хариуцлага

35.1. Монгол улсын агаарын тээвэрлэгч нь агаарын хөлгийн зорчигч амь насаа алдсан, хүнд гэмтэл авсан, эсхүл ачаа, тээш, шуудан гэмтсэн, алдагдсан болон гуравдагч этгээдэд учруулсан хохирлын нөхөн олговор олгох зорилгоор хариуцлагын даатгалд хамрагдсан байх үүрэгтэй. [ИНХ 30.2, ИНХ 38.1](#)

35.2. Энэ зүйлд заасан даатгалын бодлого, эсхүл Сайдын баталсан агаарын тээвэрлэгчийн даатгалын төлөвлөгөөний дагуу олгох нөхөн олговор нь агаарын хөлгийн техник үйлчилгээ, үйл ажиллагаанаас үүдэлтэй хохирлыг барагдуулахад хүрэлцээтэй байх ёстой. [§901.h](#)

35.3. Олон улсын агаарын тээврийн үйл ажиллагааны үед зорчигч амь насаа алдсан, хүнд гэмтэл авсан, эсхүл ачаа, тээш, шуудан гэмтсэн, алдагдсан болон гуравдагч этгээдэд хохирол учирсан тохиолдолд олон улсын агаарын тээврийн талаарх Монреалийн конвенцийг мөрдөнө. [Монреалийн конвенци 135 үлс](#)

35.4. Орон нутгийн агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа тээвэрлэгчийн хариуцлага нь дараах хэмжээтэй байна: [Монреалийн конвенциос санаа авч 2 дахин багасгае](#)

35.4.1. тээвэрлэлтийн үед зорчигч амь насаа алдсан, эсхүл хүнд гэмтэл авсан тохиолдолд нэг зуун наян сая (180,000,000) төгрөг; [\(олон улсад 100,000 SDR-Special Drawing Right \(1SDR=\\$1.39=3600төгрөг, 1USD=2590 төгрөг\)\) Монреалийн конвенци 21](#)

35.4.2. тээвэрлэлтийн үед ачаа, тээш алдагдсан, гэмтсэн, саатсан тохиолдолд зорчигч нэг бүрд нэг сая найман зуун мянган (1,800,000) төгрөг хүртэл; [\(олон улсад 1131 SDR\) Монреалийн конвенци 22](#)

35.4.3. ачаа, тээш алдагдсан, гэмтсэн, саатсан тохиолдолд тээвэрлүүлэхээр мэдүүлсэн ачааны килограмм тутамд гучин мянган (30,000) хэтрэхгүй; [\(олон улсад 19 SDR/кг\) Монреалийн конвенци 22](#)

35.4.4. тусгайлан мэдүүлсэн зорчигчийн ачаа, тээш алдагдсан, гэмтсэн, саатсан тохиолдолд хохирлын дээд хязгаар нь найман сая таван зуун мянган (8,500,000) төгрөг хүртэл. [\(4694 SDR Монреалийн конвенци 22\)](#)

35.5. Олон улсын болон орон нутгийн агаарын тээврийн үйл ажиллагааны үед зорчигч, гуравдагч этгээд амь насаа алдсан, эсхүл хүнд гэмтэл авсан тохиолдолд агаарын тээвэрлэгч энэ хуулийн 35.3, 35.4.1-д заасан даатгалын нөхөн олговрын 15 хувийг тухайн ослын хохирогчийг таньж тогтоосноос хойш 15 хоногийн дотор үл маргах журмаар урьдчилан төлөх үүрэгтэй. [\(EC\) No 2027/97](#)

35.6. Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь албан үүргээ гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн багийн гишүүд амь насаа алдсан, эсхүл хүнд гэмтэл авсан тохиолдолд хохирлыг нөхөн төлөх зорилгоор даатгуулсан байх үүрэгтэй. [ИИмХ 37.1](#)

35.7. Агаарын тээвэрлэгч нь тээвэрлэлтийн гэрээний нөхцөлийг гэрээ байгуулахаас өмнө гэрээлэгч этгээдэд танилцуулна.

36 дугаар зүйл. Агаарын тээвэрлэгчийн өмчлөлд тавих хязгаарлалт

36.1. Монгол Улсын агаарын тээвэрлэгчийн өмчлөлийн 51-ээс доошгүй хувь нь Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд байна.

36.2. Гадаадын нэг улсын иргэн, хуулийн этгээдийн нийлбэр хувь Монгол улсын агаарын тээвэрлэгчийн өмчлөлд 30 хувиас илүүгүй байна.

36.3. Агаарын тээвэрлэгч нь өөрийн өмчлөлийн харьцаанд орсон аливаа өөрчлөлтийг Сайдад мэдэгдэх үүрэгтэй.

37 дугаар зүйл. Агаарын тээвэр дэх өрсөлдөөн

37.1. Агаарын тээвэрт өрсөлдөөнгүй дангаар ноёрхох байдал үүссэн болон орон нутгийн алслагдсан бүс нутагт нийгмийн зайлшгүй үйлчилгээг нөхөн олговортой гүйцэтгэж байгаагаас бусад тохиолдолд дотоодын агаарын тээврийн үйл ажиллагааны үнийг (тариф) төрөөс зохицуулахгүй.

37.2. Нэг зах зээлд үйлчилж байгаа агаарын тээвэрлэгчид ижил нөхцөлтэй үйлчилгээнд ижил үнэ тогтоохыг хориглоно.

37.3. Иргэний нисэхэд өрсөлдөгчгүй үзүүлдэг үйлчилгээгээ бусдад үзүүлэхээс татгалзах, эсхүл зах зээлийн үнэлгээнээс өндөр үнэлэн өөртөө давуу байдал үүсгэхийг хориглоно.

37.4. Агаарын тээвэрлэгч нь өөрийн өрсөлдөгч болон түүний бүтээгдэхүүнийг нэр зааж харьцуулсан зар сурталчилгаа явуулахыг хориглоно. [Зар сурталчилгааны тухай 7.2.1.](#)

38 дугаар зүйл. Гадаадын агаарын тээвэрлэгчид зөвшөөрөл олгох

38.1. Гадаадын агаарын тээвэрлэгчийг Сайдын зөвшөөрөлгүйгээр тухайн улс болон Монгол Улсын хооронд агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно. [§902.a](#)

38.2. Дараах шаардлагыг хангасан гадаадын агаарын тээвэрлэгчид Сайд зөвшөөрөл олгож болно: [§902.b, ИИХ 7.1.11](#)

38.2.1. гадаадын агаарын тээвэрлэгч нь тухайн улсын Засгийн газрын эрх бүхий байгууллагаас олон улсын агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэхээр Монгол Улстай байгуулсан гэрээний нөхцөлийн дагуу томилогдсон байх; [§902.b.2](#)

38.2.2. олон улсын агаарын тээврийн үйл ажиллагааг зохих ёсоор гүйцэтгэх чадвартай, энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг хангасан байх; [§902.b.1, §902.c](#)

38.2.3. Монреалийн конвенцийн шаардлагыг хангасан хариуцлагын даатгалтай байх; [§902.e, ИИХ 30.2](#)

38.2.4. тухайн зөвшөөрлийг олгох нь Монгол улсын агаарын тээвэрлэгчийн ашиг сонирхолд харшлахгүй байх. [§902.b.2, БББ 2020 3.9](#)

38.3. Гадаадын агаарын тээвэрлэгч нь энэ хууль болон иргэний нисэхийн дүрэм болон энэ зүйлийн [38.2](#)-ын дагуу олгосон зөвшөөрлийн эрх, хязгаарлалтыг зөрчсөн тохиолдолд Сайд тухайн зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгоно. [§902.d.1](#)

38.4. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд, энэ хуулийн [38.2](#)-т заасны дагуу олгосон зөвшөөрлийг түдгэлзүүлэх, өөрчлөх, эсхүл хүчингүй болгох хүсэлтийг Сайдад гаргаж болно. [§902.d.2](#)

38.5. Гадаадын агаарын тээвэрлэгчийг Монгол Улсын нутаг дэвсгэрийн дотор нэг цэгээс нөгөө цэгийн хооронд агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно. [Кон. 7 каботаж](#)

8. БҮЛЭГ. ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

39 дүгээр зүйл. Иргэний нисэхийн үйлчилгээний байгууллага

39.1. Агаарын навигаци, аэродром болон нисэхийн аюулгүйн хамгаалалтыг багтаасан иргэний нисэхийн үйлчилгээг энэ хууль болон холбогдох иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн байгууллага үзүүлнэ.

39.2. Иргэний нисэхийн үйлчилгээ үзүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзах, эсхүл зах зээлийн үнээс өндөр үнэ тариф тогтоохыг хориглоно.

39.3. Олон улсын иргэний нисэхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх болон орон нутгийн нислэгийн аюулгүй байдлыг тасралтгүй хангах зорилгоор иргэний нисэхийн үйлчилгээний байгууллагад ажил хаяхыг хориглоно.

40 дүгээр зүйл. Агаарын навигацийн үйлчилгээ

40.1. Монгол Улсын агаарын зайд, агаарын навигацийн үйлчилгээг иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн төрийн өмчит агаарын навигацийн байгууллага дараах зорилгоор үзүүлнэ: [§408, 2020 БББ 5.2.1, ИНХ 24.1](#)

40.1.1. агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөнийг зохицуулах; [§409.a.1](#)

40.1.2. агаарын хөлгийг таньж тогтоох, болзошгүй аюулаас урьчилан сэргийлэх, нислэгийн хөдөлгөөнийг удирдан чиглүүлэх; [§409.a.2](#)

40.1.3. газар дээр байгаа хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах; [§409.a.3](#)

40.1.4. агаарын хөлгүүд агаарт, эсхүл газартай мөргөлдөхөөс сэргийлэх, агаарын зайг үр дүнтэй ашиглах зорилгоор нислэгийн аюулгүй өндрийг тогтоох. [§409.a.4](#)

40.2. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь Чикагогийн конвенцийн Зүйл 28-ын шаардлагыг суурь түвшинд хангах зорилгоор нислэг үйлдэх агаарын замыг агаарын навигацийн төхөөрөмжөөр тоноглогосон байна. [§409.b, §607.a, ANS 7.003, Кон.28, ИНХ 24.3](#)

40.3. Агаарын навигацийн үйлчилгээнд ашигладаг нисэхийн холбоо, навигаци, ажиглалтын тоног төхөөрөмжийн нэгдсэн сүлжээ нь төрийн өмчлөлд байна. [БББ 2020 9.8, ИНХ 10.1](#)

40.4. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь Монгол Улсын агаарын навигацийн үйлчилгээнд ашиглах нисэхийн, газрын гадаргуугийн, саадын болон аэродромын зургийг агуулсан нисэхийн өгөгдлийн нэгдмэл санг бүрдүүлэх үүрэгтэй. [Кон. Хавсралт 15](#)

41 дүгээр зүйл. Агаарын зайн зохицуулалт

41.1. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн дагуу агаарын зайн зохицуулалтыг хийхдээ үндэсний аюулгүй байдал, нислэгийн үйл ажиллагааны хэрэгцээ шаардлага болон Монгол Улсын агаарын зайгаар дамжин өнгөрөх нислэгээр зорчигчдын эрх ашгийг эрхэмлэх үүрэгтэй. [§409.d](#)

41.2. Гадаадын иргэн, хуулийн этгээд нь Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх агаарын хөлгийн нислэгтэй холбоотой мэдээллийг агаарын навигацийн үйлчилгээний байгууллагад урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авах үүрэгтэй. [ИНХ 30.3.](#)

41.3. Аливаа агаарын хөлөг нь Монгол Улсын агаарын зайд тогтоосон агаарын хаалгаар, агаарын навигацийн үйлчилгээний байгууллагын зөвшөөрөлтэй нэвтэрч, тогтоосон агаарын замаар нислэг үйлдэнэ.

42 дугаар зүйл. Зөрчил гаргасан агаарын хөлөг

42.1. Дараах агаарын хөлгийг зөрчил гаргасан агаарын хөлөг гэж үзнэ: [ИНХ 24.5, ANS 7.007, Annex2](#)

42.1.1. бодит ажиглалтын төхөөрөмж ашиглан зөв таньж тогтоогдоогүй байдалтай Монгол улсын агаарын зайд нэвтэрсэн; [Doc9433 1.2.1.a](#)

42.1.2. Монгол Улсын агаарын зайд эрх бүхий байгууллагын зохих зөвшөөрөлгүй нэвтэрсэн; [Doc9433 1.2.2.a](#)

42.1.3. зөвшөөрөлд заасан агаарын хаалгаас өөр цэгээр нэвтэрсэн; [Doc9433 1.2.2.b](#)

42.1.4. цэргийн үйл ажиллагааны болон хязгаарлалттай бүсэд зөвшөөрөлгүй нэвтэрсэн; [Doc9433 1.2.1.b](#)

42.1.5. бусад агаарын хөлөгт аюул учруулж байгаа; [Doc9433 1.2.2.c](#)

42.1.6. нислэгийн төлөвлөгөөнд заасан, эсхүл Агаарын навигацийн үйлчилгээний байгууллагын тогтоосон замаас хүндэтгэх шалтгаангүйгээр хазайсан; [Doc9433 1.2.1.c](#)

42.1.7. Монгол улсын хууль болон Чикагогийн конвенцийг зөрчин хууль бус бараа, эсхүл этгээдийн тээвэрлэлтэд сэжиглэгдэж байгаа. [Doc9433 1.2.1.d](#)

42.2. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь энэ хуулийн 42.1-д заасан агаарын хөлгийн тухай мэдээллийг Монгол Улсын батлан хамгаалах асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагад мэдэгдэж, агаарын хөлгийн нисэх багт зөрчлөө нэн даруй зогсоох, эсхүл заасан газарт буух шаардлага тавих үүрэгтэй. [ИНХ 24.6, ANS 7.007](#)

42.3. Монгол улсын бүртгэлтэй, эсхүл Монгол Улсын агаарын тээвэрлэгчийн ашиглаж байгаа агаарын хөлгийн дарга гадаад улсын агаарын зайд нислэг үйлдэж байх үедээ албадан саатуулагдах /interception/ нөхцөл байдалд орсон тохиолдолд тухайн улсын эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагыг дагаж мөрдөх үүрэгтэй.

[Finding LEG/04, OPS 4.015, Annex 2 \(3.8 Interception\)](#)

43 дугаар зүйл. Аюул тулгарсан агаарын хөлөгт тусламж үзүүлэх

43.1. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь Монгол улсын нутаг дэвсгэр дээр аюул тулгарсан агаарын хөлгийн талаар зохих журмын дагуу холбогдох байгууллагад мэдэгдэх үүрэгтэй. [ANS 7.005](#)

43.2. Чикагогийн конвенцийн Зүйл 25-ын дагуу аюул тулгарсан агаарын хөлөгт тусламж үзүүлэх, эрэн хайх, авран туслах үйл ажиллагааг тухайн агаарын хөлгийн эзэмшигч, эсхүл бүртгэгч улсын эрх бүхий байгууллага, Улсын онцгой комисстой хамтран гүйцэтгэнэ. [ANS 7.005, ИНХ 29.1, ИНХ 29.5](#)

43.3. Нутгийн захиргааны байгууллага нь аюул тулгарсан агаарын хөлгийн тухай мэдээллийг холбогдох байгууллагад нэн даруй хүргүүлж, зорчигчид болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, эмнэлгийн болон бусад зайлшгүй тусламж үзүүлэх үүрэгтэй.

44 дүгээр зүйл. Аэродромын үйл ажиллагаа

44.1. Гэрчилгээжсэн суудлын багтаамж нь 30-аас дээш зорчигчтой, тогтмол агаарын тээврийн үйл ажиллагаанд ашигладаг агаарын хөлөгт үйлчлэх аэродром нь энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн байна. [§607.b.1, §607.b.2, ICAO, Doc 9734, 3.7.3, 3.7.3.7](#)

44.2. Нисэх буудлын үйлчилгээний байгууллага нь төрийн өмчит аэродромуудыг нэгдсэн удирдлагаар хангах үүрэгтэй бөгөөд бусад аэродромыг гэрээгээр мэргэжлийн удирдлагаар хангаж болно.

44.3. Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь Олон улсын иргэний нисэхийн байгууллагын шаардлагын дагуу, тухайн аэродромыг үйл ажиллагаандаа тохирсон төхөөрөмжөөр тоноглож, нислэгийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй. [§607.b.2](#)

44.4. **Таван мянгаас** дээш тооны байнгын оршин суугчтай суурин газарт аэродром байгуулах газрыг нутгийн захиргааны байгууллага нь иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авна. [2020 БББ, 6.2](#)

44.5. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нислэгийн аюулгүй байдлын шаардлагад үндэслэн, аэродром орчмын аюулгүйн бүсийг тухайн хот, аймаг, сумын Засаг даргатай хамтарч тогтооно. [2020 БББ, 6.2.1, ИНХ 20.1](#)

45 дугаар зүйл. Аэродромын өмчлөл

45.1. Олон улсын нислэгт ашигладаг аэродром, тоног төхөөрөмж, барилга байгууламж нь төрийн өмчлөлд байна. [2020 БББ, 6.2.4](#)

45.2. Олон улсын дамжин өнгөрөх нислэгт агаарын навигацийн үйлчилгээ үзүүлдэг, улсын нисэхтэй хамтран ашигладаг агаарын навигацийн байгууламж байрласан аэродром нь төрийн өмчлөлд байна.

46 дугаар зүйл. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ

46.1. Чикагогийн конвенцийн Хавсралт 17-гийн дагуу нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн, нисэхийн аюулгүйн хамгаалалтын байгууллага гүйцэтгэнэ. [LEGs 1.005](#), [LEGs 1.010](#)

46.2. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ нь аюулгүйн үзлэг болон аэродром, агаарын навигацийн байгууламжийн харуул хамгаалалтын үйлчилгээнээс бүрдэнэ.

46.3. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын байгууллага нь иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэгтэй. [LEGs 1.010](#)

46.4. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын байгууллага нь аюулгүйн хамгаалалттай холбоотой хууль, дүрмийг зөрчсөн этгээдийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх зорилгоор саатуулах эрхтэй. [LEGs 1.095](#), [§410.c](#)

47 дугаар зүйл. Аюулгүйн үзлэг

47.1. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын байгууллага нь Олон улсын нислэг үйлдэх агаарын хөлөгт нэвтрэн орох аливаа этгээд болон тээвэрлэх ачаа, тээш, шууданд галт зэвсэг, тэсрэх бодис болон агаараар тээвэрлэхийг хориглосон бусад эд зүйлсийг илрүүлэх зорилгоор аюулгүйн үзлэг хийнэ. [§410.a](#), [ИНХ 40.1](#)

47.2. Энэ хуулийн дагуу гүйцэтгэж байгаа аюулгүйн үзлэг хийлгэхээс татгалзсан этгээдийг нисэхийн аюулгүйн хамгаалалтын бүсэд нэвтрэхийг хориглоно. [ИНХ 40.2](#)

48 дугаар зүйл. Аэродром, агаарын навигацийн байгууламжийн хамгаалалт

48.1. Олон улсын нислэгт үйлчилдэг аэродром болон агаарын навигацийн байгууламж нь нисэхийн аюулгүйн хамгаалалтын байгууллагын хамгаалалтад байна. [§410.b](#)

48.2. Энэ хуулийн [48.1](#)-д заасан харуул хамгаалалт шаардлагатай аэродром болон агаарын навигацийн байгууламжийн жагсаалтыг Дарга батална. [ИНХ 31.2](#)

9. БҮЛЭГ. АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ

49 дүгээр зүйл. Шинжлэн шалгах байгууллага

49.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт гарсан агаарын хөлгийн осол, зөрчлийг Шинжлэн шалгах байгууллага гүйцэтгэнэ. [ШШ Загвар 4 \(a\)](#), [ШШ Загвар 5](#); [AIG 6.003](#), [ИНХ 42.1](#) [ШШ Загвар 8](#)

49.2. Шинжлэн шалгах байгууллага нь иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон иргэний нисэхийн бусад байгууллагаас хараат бус, бие даасан байна. [ШШ Загвар 10](#), [AIG 6.005](#), [6.011](#)

49.3. Шинжлэн шалгах байгууллага нь энэ хуулиар олгогдсон эрхийн хүрээнд шинжлэн шалгах ажиллагааг бүрэн гүйцэд явуулахад шаардлагатай төсөвтэй байна. [ШШ Загвар 17.б](#)

49.4. Шинжлэн шалгах ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг хангах зорилгоор шинжлэн шалгах байгууллагын шинжлэн-шалгагчийн цалин хөлсний сүлжлийг Засгийн газрын санал болгосноор Улсын Их Хурал батална. [Дос 9734 \(3.4.2.1, 3.4.2.3\), БББ 2020](#)

49.5. Үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг хангаж, шинжлэн шалгах ажиллагааг үнэн зөв гүйцэтгэх зорилгоор Шинжлэн шалгах байгууллагын ажилтнууд нь ашиг сонирхлын зөрчилгүй байна. [ШШ Загвар 21](#)

49.6. Монгол улсын бүртгэлтэй агаарын хөлгийн осол, зөрчил аль улсын нутаг дэвсгэрт гарсан нь тогтоогдоогүй, эсхүл тухайн осол, зөрчил гарсан улс нь Хэлэлцэн тохирогч улс биш бол Шинжлэн шалгах байгууллага шинжлэн шалгах ажиллагааг энэ хуулийн дагуу гүйцэтгэнэ. [ШШ Загвар 4\(б\)\(i\), \(ii\)](#)

49.7. Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг тус улсын нутаг дэвсгэрийн гадна осол, зөрчилд өртсөн тохиолдолд шинжлэн шалгах ажиллагааг олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу гүйцэтгэх ба Монгол Улсын нэрийн өмнөөс Шинжлэн шалгах байгууллага оролцож болно. [ШШ Загвар 4\(а\), ИНХ 42](#)

49.8. Энэ хуулийн дагуу гүйцэтгэх шинжлэн шалгах ажиллагааны үндсэн зорилго нь осол, зөрчлийг давтан гарахаас урьдчилан сэргийлэхэд оршино. [ШШ Загвар 6](#)

49.9. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа нь гэм буруутныг тогтоох, хариуцлага хүлээлгэх зорилготой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас ангид байна. [ШШ Загвар 7](#)

49.10. Энэ хуулийн дагуу шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэж байгаа шинжлэн-шалгагч нь осол, зөрчилтэй холбоотой бүх нотлох баримт, барилга байгууламжид аль ч үед саадгүй нэвтрэх эрхтэй. [ШШ Загвар 9, ИНХ 43.3.2](#)

49.11. Шинжлэн шалгах байгууллага нь агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэх бол бусад хууль тогтоомжид зааснаас үл хамааран, төрийн бусад байгууллагыг Чикагогийн конвенцийн Хавсралт 13-ын зорилгоор шинжлэн шалгах ажиллагаа гүйцэтгэхийг хориглоно. [ШШ Загвар 22; AIG 6.028, 6.359](#)

49.12. Энэ хуулийн **49.11** дэх хэсэг нь хууль хяналтын болон бусад байгууллага агаарын хөлгийн осол, зөрчлийг энэ хуульд зааснаас өөр зорилгоор шинжлэн шалгах ажиллагаа гүйцэтгэхийг хориглоогүй. [ШШ Загвар 23, ШШ Загвар 24](#)

49.13. Шинжлэн шалгах байгууллага нь осол, зөрчилтэй холбоотой мэдээллийг цуглуулах, бүртгэх, ангилах, дүн шинжилгээ хийх, шаардлагатай тохиолдолд аюулгүй байдлын зөвлөмж гаргах, ослын шалтгаан болон осолд нөлөөлсөн хүчин зүйлийг тогтоож, шинжлэн шалгах ажиллагааны эцсийн тайланг гаргана. [ШШ Загвар 11.а, b, c, d, ШШ Загвар 26; AIG 6.501](#)

49.14. Шинжлэн шалгах байгууллагын ажилтнууд нь осол, зөрчлийг хянан шийдвэрлэх болон шүүн таслах ажиллагаанд гэрчээр оролцохгүй. [ШШ Загвар 32](#)

50 дугаар зүйл. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах

50.1. Агаарын хөлгийн эзэмшигч, ашиглагч, хөлгийн дарга, нисэх багийн гишүүд, аэродром болон агаарын навигацийн үйлчилгээний байгууллагын ажилтан нь осол, зөрчлийн дэлгэрэнгүй мэдээллийг Шинжлэн шалгах эрх бүхий байгууллагад нэн даруй, боломжит хэлбэрээр мэдээлэх үүрэгтэй. [ШШ Загвар 26](#)

50.2. Шинжлэн шалгах эрх бүхий байгууллага осол, зөрчлийн мэдээллийг хүлээн авмагц шаардлагатай шинжлэн шалгах ажиллагааг нэн даруй эхлүүлэх үүрэгтэй. [ШШ Загвар 27](#)

50.3. Осол, зөрчилд өртсөн агаарын хөлгийн эзэмшигч, агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч болон багийн гишүүд нь агаарын хөлөг, түүнд байгаа эд зүйлийг багтаасан нотлох баримтыг тухайн шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэж дуусах хүртэл аюулгүй хадгалан хамгаалах боломжит бүх арга хэмжээг авах үүрэгтэй. [ШШ Загвар 28](#)

50.4. Иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч нь осол, зөрчилтэй холбоотой бүх төрлийн бичлэг, нотлох баримтыг хадгалан хамгаалах үүрэгтэй. [AIG 6.357](#)

50.5. Энэ хуулийн 50.3, 50.4-д заасныг үл харгалзан аливаа этгээд нь осол, зөрчилтэй холбоотой хүн, эд хөрөнгийн аюулгүй байдлыг хангах, нотлох баримтыг гадны нөлөөнөөс хамгаалах боломжит бүх арга хэмжээ авах үүрэгтэй. [ШШ Загвар 29](#), [ШШ Загвар 30](#)

50.6. Агаарын хөлгийн осол, зөрчил Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гарсан тохиолдолд иргэн, нутгийн захиргааны байгууллага, цагдаа болон батлан хамгаалахын анги салбарууд Шинжлэн шалгах байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай туслалцааг цаг алдалгүй үзүүлэх үүрэгтэй. [ИНХ 42.5](#)

51 дүгээр зүйл. Шинжлэн шалгах байгууллагын даргын бүрэн эрх

51.1. Шинжлэн шалгах байгууллагын дарга нь тухайн байгууллагыг өдөр тутмын удирдлагаар хангах үүрэгтэй бөгөөд байгууллагын ажлыг Сайдын өмнө шууд хариуцна.

51.2. Шинжлэн шалгах байгууллагын дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: [ШШ Загвар 18](#)

51.2.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт болон гадаад улсын нутаг дэвсгэрт гарсан Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлгийн осол, зөрчлийн бодит шалтгааныг тогтоох зорилгоор шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэх; [ШШ Загвар 18 \(b\)](#), [ИНХ 43.2.1](#)

51.2.2. агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааг Хэлэлцэн тохирогч улсын шинжлэн шалгах эрх бүхий байгууллагатай хамтран гүйцэтгэх, эсхүл түүнд хэсэгчлэн, эсхүл нийтэд нь бүрэн шилжүүлэх асуудлыг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх; [ШШ Загвар 18 \(c\)](#), [ИНХ 43.3.1](#)

51.2.3. Шинжлэн шалгах байгууллагын төсвийг хууль тогтоомжийн хүрээнд шинжлэн шалгах ажиллагаанд зориулан захиран зарцуулах;

51.2.4. Шинжлэн шалгах байгууллагын ажилтан, шинжлэн-шалгагчийг томилох; [AIG 6.121](#)

51.2.5. агаарын хөлгийн осол, зөрчлийн шинж чанараас хамааран тухайн шинжлэн шалгах ажиллагааг удирдан зохион байгуулах хариуцсан шинжлэн-шалгагч, шинжлэн шалгах багийн гишүүдийг томилох; [ШШ Загвар 18.d, e](#)

51.2.6. шинжлэн шалгах ажиллагааны эцсийн тайланг батлах. [ШШ Загвар 18.f](#)

52 дугаар зүйл. Шинжлэн-шалгагчийн бүрэн эрх

52.1. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд оролцох шинжлэн-шалгагч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: [ИНХ 43.2](#)

52.1.1. албан үүргээ гүйцэтгэхдээ осол, зөрчилд холбоотой бүх объект, барилга байгууламжид аль ч үед саадгүй нэвтрэх; [ШШ Загвар 9, ИНХ 43.3.2](#)

52.1.2. шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагатай мэдээ, судалгаа, тодорхойлолт болон бусад нотлох баримтыг холбогдох хувь хүн, хуулийн этгээдээс шаардан гаргуулж авах; [ИНХ 43.3.3](#)

52.1.3. байгалийн хүнд нөхцөлд ажиллахад шаардагдах хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл, тоног төхөөрөмж, холбоо, тээврийн хэрэгслээр хангагдах; [ИНХ 43.3.5](#)

52.1.4. ерөнхий шинжлэн шалгагчийн олгосон бусад эрх. [ИНХ 43.3.6](#)

53 дугаар зүйл. Хариуцсан шинжлэн-шалгагчийн бүрэн эрх

53.1. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааг удирдан зохион байгуулах хариуцсан шинжлэн-шалгагч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: [ШШ Загвар 19](#)

53.1.1. осол, зөрчил болсон газарт аль ч үед саадгүй нэвтрэх, шинжлэн шалгах ажиллагаанд хамааралтай ослын үлдэгдэл, бүх төрлийн эд материалд бүрэн хяналтаа тогтоох; [ШШ Загвар 25\(a\), ШШ Загвар 9; AIG 6.021](#)

53.1.2. нислэгийн бичлэгийн төхөөрөмж, тухайн нислэгийн үйл ажиллагаатай холбоотой агаарын навигацийн үйлчилгээний бичлэгүүд зэрэг бусад нотлох баримтыг өөрийн бүрэн хяналтад авах; [ШШ Загвар 25\(b\), AIG 6.023](#)

53.1.3. шинжлэн шалгах ажиллагааны явцад эд мөрийн баримтыг хамгаалах, агаарын хөлөг, түүний үлдэгдэл байгаа бүсэд зөвшөөрөлгүй этгээд нэвтрэх, эд зүйл үрэгдэж гэмтэх, алдагдахаас хамгаалах боломжит бүх арга хэмжээг авах; [ШШ Загвар 25\(d\), AIG 6.355](#)

53.1.4. шинжлэн шалгах ажиллагааны явцыг Шинжлэн шалгах байгууллагын даргад илтгэх, илрүүлсэн ослын боломжит шалтгаан, нөлөөлсөн байж болох хүчин зүйлд тулгуурлан Аюулгүй байдлын зөвлөмж гаргах; [ШШ Загвар 20\(a\)](#)

53.1.5. шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай ажиглагч, оролцогчийг томилох; [ШШ Загвар 20\(b\)](#)

53.1.6. шинжлэн шалгах ажиллагааг цаг алдалгүй эхлүүлэх зорилгоор холбогдох эд мөрийн баримт, агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн үлдэгдлийг өөрийн бүрэн хяналтад авах; [ШШ Загвар 25\(c\), AIG 6.025, 6.027](#)

53.1.7. ослын газрын хамгаалалтыг буулгах, шинжлэн шалгах ажиллагаанд цаашид шаардлагагүй болсон агаарын хөлөг, түүний бүрдэл хэсэг, эд зүйлсийг хадгалалтаас чөлөөлөх; [ШШ Загвар 25\(е\)](#)

53.1.8. иргэний нисэхийн инженер, техникийн мэргэжилтний зөвлөгөө авах; [AIG 6.109](#)

53.1.9. осол, зөрчлийн газрыг хамгаалалтад авах зорилгоор эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх; [ИНХ 4.3.1](#)

53.1.10. шинжлэн шалгах ажиллагааны тайлангийн төсөл гаргах;

53.1.11. хууль тогтоомжоор олгосон бусад эрх.

54 дүгээр зүйл. Шинжлэн шалгах ажиллагааны тайлан

54.1. Шинжлэн шалгах байгууллага, шинжлэн шалгах ажиллагааны тайланг гаргахаас өмнө, тухайн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд хамааралтай байгууллага, хамтран оролцсон улс болон эрх бүхий байгууллагуудаас санал авах зорилгоор тайлангийн төслийг хүргүүлнэ. [ШШ Загвар 33](#)

54.2. Шинжлэн шалгах байгууллага, агаарын хөлгийн осол, зөрчил давтан гарахаас сэргийлэх зорилгоор шинжлэн шалгах ажиллагааны тайланг боломжит богино хугацаанд гаргана. [ШШ Загвар 34](#)

54.3. Нууц мэдээллийг нээлттэй болгох нь шинжлэн шалгах ажиллагаанд ач холбогдолтой болохыг эрх бүхий байгууллага тогтоосноос бусад тохиолдолд, шинжлэн шалгах ажиллагааны тайлангийн төсөл, нотлох баримтыг хуульд зааснаас өөр зорилгоор зөвшөөрөлгүйгээр задруулах, түгээхийг хориглоно. [ШШ Загвар 12](#), [ШШ Загвар 31](#), [AIG 6.029](#), [AIG 6.031](#)

54.4. Агаарын хөлгийн осол, зөрчлийн шинжлэн шалгах ажиллагааны тайланг гэм буруутныг тогтоох, хариуцлага оногдуулахтай холбоотой шүүхийн болон бусад ажиллагаанд нотлох баримтаар ашиглахгүй. [ШШ Загвар 13](#)

54.5. Энэ хуулийн дагуу хийгдсэн шинжлэн шалгах ажиллагааны тайлан болон аюулгүй байдлын зөвлөмжийг эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэх, эсхүл гэм буруутныг тогтооход нотлох баримтаар ашиглахыг хориглоно. [ШШ Загвар 13](#), [ШШ Загвар 14](#), [ШШ Загвар 15](#)

55 дугаар зүйл. Аюулгүй байдлын зөвлөмж

55.1. Шинжлэн шалгах байгууллага, нислэгийн аюулгүй байдлыг сайжруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор шинжлэн шалгах ажиллагааны аль ч үе шатанд Аюулгүй байдлын зөвлөмж гаргаж болно. [ШШ Загвар 35](#)

55.2. Аюулгүй байдлын зөвлөмжийг агаарын хөлөг үйлдвэрлэгч, иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон бусад холбогдох байгууллагад, шаардлагатай бол Олон улсын иргэний нисэхийн байгууллагад хүргүүлнэ. [ШШ Загвар 36](#)

55.3. Аюулгүй байдлын зөвлөмжийг хүлээн авсан этгээд нь зөвлөмжийн дагуу шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн хариу мэдэгдэх үүрэгтэй.

55.4. Энэ хуулийн 55.3-т заасан Аюулгүй байдлын зөвлөмжийг хүлээн авсан этгээд нь тухайн зөвлөмжийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь хүлээн зөвшөөрөхгүй байх

бодит үндэслэл байгаа бол тайлбарыг Шинжлэн шалгах байгууллагад нэн даруй хүргүүлэх үүрэгтэй.

56 дугаар зүйл. Шинжлэн шалгах ажиллагааг сэргээх

56.1. Шинжлэн шалгах ажиллагаа дууссаны дараа тухайн ажиллагааны үр дүнг өөрчилж болох баримт, нөхцөл байдал шинээр илэрсэн тохиолдолд Шинжлэн шалгах байгууллагын дарга шинжлэн шалгах ажиллагааг сэргээнэ. [ШШ Загвар 37](#)

10. БҮЛЭГ. БУСАД

57 дугаар зүйл. Иргэний нисэхийн үйлчилгээний хураамж

57.1. Агаарын навигацийн үйлчилгээний хураамж нь Монгол улсын агаарын зам ашигласны болон нисэх буудлын буулт, хөөрөлтийн хураамжийн төлбөрөөс бүрдэнэ.

57.2. Агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн хэмжээг тухайн агаарын замын 100 км тутамд агаарын хөлгийн хөөрөлтийн гэрчилгээжсэн дээд жингээр ангилан Дарга тогтооно.

57.3. Монгол улсын бүртгэлтэй агаарын хөлгийг дараах тохиолдолд агаарын навигацийн үйлчилгээний хураамжаас чөлөөлнө:

57.3.1. агаарын хөлгийн хөөрөлтийн гэрчилгээжсэн дээд жин 2000 килограммаас ихгүй бол;

57.3.2. гамшгаас хамгаалах нислэг;

57.3.3. орон нутгийн алслагдсан бүс нутгуудыг холбох нийгмийн зайлшгүй шаардлагатай нислэг; [БББ 2020](#)

57.3.4. агаарын навигацийн болон аэродромын төхөөрөмжийн тохируулга хийх шалгах нислэг;

57.3.5. осолд өртсөн агаарын хөлгийг эрэн хайх, авран туслах болон ослын хохирогчдын гэр бүлийн гишүүдийг тээвэрлэх захиалгат нислэг; [AIG 6.383](#)

57.4. Нисэх буудлын үйлчилгээний хураамжийн дээд хязгаарыг агаарын хөлгийн хөөрөлтийн гэрчилгээжсэн дээд жингийн ангиллаар Дарга тогтооно. [2020 БББ 9.7.6](#)

58 дугаар зүйл. Үнэмлэх гэрчилгээтэй холбоотой гомдол гаргах

58.1. Онцгой нөхцөлөөс бусад тохиолдолд Дарга үнэмлэх, гэрчилгээг түдгэлзүүлэх, өөрчлөх, хүчингүй болгох шийдвэр гаргахын өмнө тухайн гэрчилгээ, эсхүл үнэмлэх эзэмшигчид тайлбар өгөх боломж олгох үүрэгтэй. [§610.c](#)

58.2. Үнэмлэх, гэрчилгээнд нь үндэслэлгүйгээр өөрчлөлт оруулсан, түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүйд тооцсон шийдвэрийн талаар эзэмшигч нь дээд шатны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй. [§610.d](#)

59 дүгээр зүйл. Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

59.1. Энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийг зөрчсөн үнэмлэх, гэрчилгээ эзэмшигч хувь хүн, хуулийн этгээдийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол зөрчил гаргагчийн үнэмлэх, гэрчилгээг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгоно. [ИНХ 44.1, §701](#)

59.2. Хэрэв энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийг зөрчсөн хувь хүн, хуулийн этгээд нь үнэмлэх, гэрчилгээ эзэмшигч биш бол зөрчлийг холбогдох хуулийн дагуу шийдвэрлэнэ. [ИНХ 44.1](#)

59.3. Энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийг зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдийн үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй бол Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. [ИНХ 44.2, §702](#)

ГАРЫН ҮСЭГ